

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-31

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай/ 3-10

2.Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээлэл сонсох. 10-31

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
12 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ;
Тасалсан: С.Амарсайхан, А.Адъяасүрэн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, Т.Доржханд нар үг хэлэв.

Н.Энхболд: “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, мөн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга У.Тамир, Удирдах зөвлөлийн гишүүн Д.Отгонбаяр, төслийн зохицуулагч Б.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээллийг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, мөн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга У.Тамир, Удирдах зөвлөлийн гишүүн Д.Отгонбаяр нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Т.Доржханд, Н.Энхболд нарын тавьсан асуултад Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, мөн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга У.Тамир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээлэл сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 16 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр төлөвлөөд байна. 1 дүгээрт СЕХ-ны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолын төсөл байна. Нэр дэвшигчийн сонсголын тухай хуульд Их Хурлын хянан шалгах хуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд Улсын Их Хурал сонсгол явуулна. Томилгооны сонсгол хийнэ гэсэн ийм заалттай. Энэний дагуу энэ асуудлыг хэлэлцэнэ. 2 дугаарт бусад асуудлын хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээлэл сонсох тухай асуудал байгаа. ТББХ-ны хариуцах асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.7.1-д 7.10-д хэвлэл мэдээллийн хараат бус байдлын асуудлыг ТББХ хариуцна гэж заасан байдаг учраас өнөөдөр энэ Хэвлэл мэдээллийн зөвлөлийн удирдлагуудтай уулзаж, сонсгол нөхцөл байдлын талаар сонсгол хийе гэж ингэж төлөвлөсөн байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай/

СЕХ-ны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолыг тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн дагуу СЕХ-ны гишүүд бол 6 жилийн хугацаатай сонгогддог. Тэд нарыг солих, өөрчлөх, халах хуулийн зохицуулалтууд бий. Энэ дотор СЕХ-ны гишүүн өөрөө өргөдөл өгсөн гаргасан болбол асуудлыг нь авч хэлэлцэх ийм зохицуулалт байгаа 1 дүгээрт. 2 дугаарт өнөөдөр яригдах 2 гишүүний хувьд гэвэл хоёулаа манай уламжлал ёсоор бүх сонгуулийн өмнө Цагдаагийн ерөнхий газрын дарга мөн Улсын бүртгэлийн газрын дарга заавал оролцдог, чухал үүрэг гүйцэтгэдэг СЕХ-н дээр ийм хуулийн заалт, ийм практик нөхцөл байдлууд байгаа учраас 2 хүний асуудлыг авч хэлэлцэхээр бэлдээд байна.

1 дүгээрт СЕХ ТББХ-нд хандаж өргөдөл ирүүлсэн байгаа. ЦЕГ-ын даргаар ажиллаж байсан Ж.Болд хүсэлт гаргаад Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасны дагуу Жамсранжавын овогтой Болд миний бие СЕХ-ны гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг гаргаж байна, зохих журмын дагуу Улсын Их Хуралд танилцуулан шийдвэрлүүлж өгөхийг хүсье гэсэн өргөдлөө ирүүлсэн байна. 2 дугаарт мөн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасны дагуу миний бие СЕХ-ны гишүүнээс чөлөөлөх хүсэлтийг гаргаж байна. Зохих журмын дагуу Улсын Их Хуралд танилцуулан шийдвэрлэж өгөхийг хүсье гэсэн хүсэлтээ СЕХ-ны гишүүн Б.Ганбат гаргаж ирсэн байгаа. Ингээд энэ 2 гишүүн хүсэлтээ ирүүлсний дагуу манай Байнгын хорооноос тогтоол гаргах ёстой.

Би тогтоолын төслийг уншаад танилцуулчихъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. СЕХ-ны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол

даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТББХ-ноос тогтоох нь.

1.СЕХ-ны гишүүнд нэр дэвшигч Дагвадоржийн Дэлгэрсайхан, Төмөрбаатарын Сүхболд нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.СЕХ-ны гишүүнд нэр дэвшигч нартай хийх нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарыг томилсугай.

3.Нэр дэвшигчид хандан асуух асуулт, саналыг 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл 28-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг ТББХ Н.Энхболдод даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа. Дагвадоржийн Дэлгэрсайхан бол өнөөдөр Бүртгэлийн Иргэний бүртгэлийн ерөнхий газрын УБЕГ-ын даргаар ажиллаж байгаа. Төмөрбаатарын Сүхболд ЦЕГ-ын даргаар ажиллаж байгаа. ТББХ-ноос эдгээр хүмүүсийн нэрийг нь дэвшүүлж байгаа хуулийн дагуу. Ийм зохицуулалттай. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуух асуулт гишүүд нэрээ өгье. Асуулт алга. Санал үг хэлэх гишүүн байна уу? Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Энэ тогтоолын төслийг бол дэмжиж байна. Энийг бол гаргах нь зөв. Энэ Энхболд даргын гаргаж байгаагаар болбол сонгууль зохион байгуулах гол ажлыг нь нуруундаа үүрдэг 2 байгууллагын өмнө нь ажиллаж байсан дарга нь гараад, орны дарга нар нь орж байгаа юм байна гэж бодож байна. Тийм учраас тогтоолын төслийг дэмжиж байна. Зүгээр цаашид бид нар 2 асуудал дээр анхаармаар юм шиг байгаа юм. Хууль зүйн хүрээнд нь 1 дүгээрт СЕХ-ны гишүүдийг энэ албан тушаалаар нь томилогддог болгочихмоор байгаа юм. Энэ цагдаагийн дарга чөлөөлөгдлөө шууд, Улсын бүртгэлийн дарга чөлөөлөгдлөө шууд нэг дэх асуудал энэ. 2 дахь нь төрийн алба хааж байгаад төрийн албанаас чөлөөлөгдчихвөл чөлөөлөгддөг болох хэрэгтэй байгаа юм. Төрийн албанаас чөлөөлөгдсөн мөртөө чөлөөлөгдөхгүй гээд байгаад байгаа хүмүүс байгаад байгаа байхгүй юу. Манай энэ Сонгуулийн төв байгууллагын хууль дээр зөвхөн өөрийн хүсэлтээр л гарна гэхчсэн нэг үгтэй, өөр юм байхгүй. Тэр нь төв байгууллагын хуулийг хөндөж яг албан тушаалаараа бол албан тушаалаараа ордог, төрийн албанаас чөлөөлөгдөх юм бол гараад дараагийн хүн ордог ийм зарчим руу явахгүй болбол ингээд тэнд суучхаад байдаг нэг ийм тохиолдол гараад байгаа юм. Энэ гол агуулга нь бид нар 2008 оноос хойш хийгдсэн нэг том өөрчлөлт чинь төрийн албаар сонгуулийн ажлыг зохион байгуулна гэж байгаа юм. Тэгэхээр төрийн албанаас чөлөөлөгдсөн бол байхгүй байх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ агуулгаар нь хуульд бол өөрчлөлт хийх хэрэгтэй байгаа юм.

2 дахь нь болбол энэ сонсгол дээр болбол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулж, сонсголын асуудлыг авч үзэхдээ энэ албан тушаалаар орж байгаа хүмүүсийг бол сонсгол хэрэггүй байхгүй юу. Жишээ нь, Цагдаагийн дарга, Улсын бүртгэлийн дарга эд нар болбол хэрэг байхгүй. Зүгээр бусад хэлбэрээр орж

байгаа бусад субъектүүдээс орж байгаа хүн дээр нь болбол ярьж болдог ийм зохицуулалтыг бас хийж өгөхгүй болбол цагдаа улсын бүртгэл 2 бол сонсголд орж ирэхээр тэгээд юу яригдах юм бол доо энэ одоо. Тийм учраас болбол энэ хоёрыг эрх зүйн хүрээнд нь бол цаашид нэг манай ТББХ нэг анхааралдаа аваад, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2 дээр энэ 2 асуудлыг бас нэг нарийн зохицуулалт хийх шаардлагатай байна гэдэг ийм саналтай байна. Баярлалаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн даргын ярьж байгаатай би бол хувь гишүүний хувьд бас санал нэг байна. Амьдрал баялаг болохоор янз бүрийн асуудлууд их тохиолдох юм. Бид нар бас хуулиа боловсруулах, батлахдаа тохиолдол болгоныг тэр болгон харж чадахгүй юмнууд бас гараад байдаг. Яг өнөөдрийн байдлаар гэхэд яг саяын хэлсэн ийм зүйлүүд зөвхөн энэ байгууллагын хувьд ч биш бусад газрууд дээр бас гараад байгаа юм. Тэгэхээр тухай тухайн үед нь Дэгийн тухай хууль холбогдох Их Хурлын тухай хууль өнөөдөр гэхэд Сонгуулийн төв байгууллагын тухай хууль ч гэдэг юм уу энэ зүйлүүддээ дараа дараагийн ажлаа их оновчтой зөв болгосон өөрчлөлтүүдийг хийж явах шаардлагатай гэдэгтэй болбол би санал нэг байна. Энийг хэдүүлээ ярья. Байнгын хороон дээрээ. Одоо ер нь Их Хурлын Үндсэн хуульд өөрчлөлт ороод Их Хурлын үйл ажиллагаанд ч гэсэн тодорхой өөрчлөлтүүд орох ёстой. Энэтэй уялдсан нэлээд олон хуулиудад Дэгийн тухай хууль, Их Хурлын тухай хууль, Гишүүний эрх зүйн байдлын тухай хууль гээд хэд хэдэн хуулиудад Үндсэн хуульд нийцүүлсэн өөрчлөлтүүд орох ёстой. Энийг бид нар шинэ Их Хурал эхлэхээс өмнө бас энэ Үндсэн хуульд орсон гол үзэл баримтлалуудыг нь Дэгийн тухай хууль бусад тухай хуулиуддаа оруулаад батлаад өгсөн байх нь зүйтэй гэсэн ийм бодлого Их Хурал барьж байгаа. Энэ чиглэлээр ч бас ажил төлөвлөгдсөн. Хуулийн төслүүд боловсруулаад явж

байгаа гэдгийг хэлье. Сүхбаатар гишүүн. Сүхбаатар гишүүний үг.

Ж.Сүхбаатар: Би энд зүгээр нөгөө Тогтохсүрэн даргын хэлж байгаа дээр бас яах вэ цаашидаа протоколд ч тэр хүмүүс зөв зүйтэй ойлгох хэрэгтэй байгаа юм. 32 жилийн өмнө, 31 жилийн өмнө ч билүү 92 он гэхээр чинь 31 жилийн өмнө байна. 31 жилийн өмнө СЕХ-г анх байгуулсан юм Улсын Их Хурлын дэргэдэх гээд. Тэгээд тэр нь болохоор зэрэг яг биеэ даасан байгууллага сонгуулийн үед зохион байгуулалт хийдэг, СЕХ-ны дарга нь бол Их Хурлын Тамгын газраасаа цалинждаг, тэгээд 1 өрөөнд л байдаг. Тэгээд бусад үед ажилладаггүй ийм байдалтай байх үед СЕХ-г албан тушаалаар нь бүрдүүлж байж зөвхөн сонгууль зохион явуулах гэдэг талаасаа төрийн байгууллагуудын хүчийг татан ашиглах ийм хэлбэрээр энэ байгууллага анх байгуулагдсан түүхтэй. Тэгээд 1996 оноос хойш нөгөө сонгуулийн хэрэг маргаан, зөрчил гараад тэрийг шийдвэрлэх боломж чадавх СЕХ байхгүй, илүү зохион явуулдаг шинж рүүгээ байгаад байсан. Тэгээд энэ гүнзгийрээд яваад байсныг нь бид нар би өөрөө сонгуулийн хүрээнд нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулаад, 5 онд СЕХ-г илүү биеэ даасан байгууллага руу шилжүүлэх хэлбэр лүү түлхэж өгсөн.

Гэхдээ энэ процесс бас амаргүй явж байгаа. Өөрөөр хэлбэл одоогийн манай СЕХ яг хараат бус, биеэ даасан, хэрэг маргааныг зөвхөн шийдвэрлэдэг, зохион явуулдаг аль алийг нь хослуулсан хүчтэй байгууллага болсон уу гэвэл бас яг болоогүй байгаа. Дэлхийн улс орнуудад олон янз байдаг байхгүй юу. Сонгуулийн хүчтэй, биеэ даасан, байнгын ажиллагаатай, нэг тийм хэрэг маргаан шийдвэрлэдэг шүүгч эд нар ордог нэг ийм байгууллага бол байгаа юм. Нөгөөдөх нь бол Статистикийн хороо нь ч юм уу, дотоод явдлын яам нь зохион байгуулдаг Европ маягийн буюу Германчуудын

хийдэг ажлууд жишээлбэл байж байх жишээтэй ч гэдэг юм уу. Тэгээд нөгөөдүүл нь болохоор зэрэг бас ингээд аль алиныг нь хослуулдаг ч байна. Тэгэхээр манай энэ СЕХ болбол яг ямар байгууллага вэ гэхээрээ зэрэг сүүлийн үед бол ингээд сүүлийн сонгуулиудаар харах юм бол сонгууль зохион явуулдаг шинжээсээ гадна бас тодорхой хэмжээний хэрэг зөрчлийг шийдвэрлэх тал руу явж эхэлж байгаа юм. Тийм учраас би 5 оноос хойш яг энэ ажлыг хариуцаж хийж байсан хүн, СЕХ маань албан тушаалаараа зөвхөн ордог тогтолцооноосоо бас харьцангуй биеэ даасан, байнгын үйл ажиллагаатай, байнгын орон тоогоор ажилладаг, тодорхой эрх бүхий этгээдүүд орж ажилладаг. Цаашидаа хөгжлийнхөө явцад илүү тэр ЗГ-ын хандлагатай сонгуулийн байгууллага биш, шүүхийн хандлагатай бас биш. Гэхдээ нэг тийм хүчтэй сонгуулийн комисс, хараат бус бие даасан байх энэ загвар луу л явж байгаа.

Солонгосын жишээлбэл загвар болбол шууд асуудлыг эцэслэн шийдвэрлэх Үндсэн хуулийн шүүхэд захирагддаггүй, ард түмний дээд хяналтыг хэрэгжүүлдэг жишээлбэл сонгуулийн төв комисс байх жишээтэй. Тэгэхээр албан тушаалаар орж байгаа хүмүүсийг бол шаардлага бол надад бол байгаа гэж харагддаг. Гэхдээ энэ тоог нь хэтрүүлж болохгүй. Эсвэл Статистикийн дарга бол зайлиггүй энэ бүртгэл, Иргэний бүртгэлийн дарга, Статистикийн дарга 2 зайлиггүй байх шаардлагатай байдаг. Цагдаагийн дарга дээр сүүлийн хэдэн сонгуулиуд дээр жоохон маргаан гаргаад байдаг юм энэ байх, байхгүй. Гэхдээ Монголд бол байх шаардлага байгаад байгаа юм. Тэгэхээр албан тушаалаар гээд хуульчилж болохгүй байсан шалтгаан нь хэрэв энэ дээр хэл ам гараад байх учраас ингээд нэг энүүгээр нь ер нь харгалзаад практикаараа ингээд оруулаад яваад байгаа. Яг ингээд хуульчилсан тохиолдолд бол тодорхой тооны 3, 4-өөс илүү хэтрэхгүйгээр бүрэлдэхүүний 1/3-

ээс хэтрэхгүй нь албан тушаалаараа байгаад, тэр хүмүүс тэр тохиолдолд бол яг Тогтохсүрэн даргын хэлдгээр бол сонсголд орох шаардлагагүй, албан тушаалаараа орж байгаа юм чинь ороод чөлөөлөгдөөд явдаг байх нь бол зөв.

Тэгэхдээ тэгэхгүй болохоор ер нь бол манайхны хуучин ойлголт бол ер нь албан тушаалаар нь бараг бүгдийг нь бүрдүүлдэг байсан учраас тэр лүүгээ хэлбийчих гээд, тэгээд Сонгуулийн байгууллага чинь түр үеийн байгууллага гэдэг байсан руу орчих вий. Одоо бол СЕХ болбол яг нөгөө хөгжлийнхөө нэлээн тийм зөв шат руугаа ингээд дэс дараалалтай явж байгаа. Одоо пропорциональ системийг сая бид хуульчилчихлаа. Улс төрийн намын тухай хуулийг шинэчилчихлээ. Цаашидаа бол СЕХ бол улс төрийн намын талаар хүлээж байгаа үүрэг хариуцлага нь хүртэл нэмэгдэж байна. Тэгэхээр нэмэгдэж байгаа нөхцөлд СЕХ албан тушаалын шинжтэй гишүүд давамгайлсан биш, мэргэжлийн тэнд ажилладаг хүмүүс давамгайлсан тэр шинж рүүгээ илүү явах ёстой юм байна. Тэгэхээр энийг бас тийм зөв ойлгуулж яахгүй бол зарим хүмүүс бол энэ албан тушаалаар ордог асуудал дээр болбол маргаан үүсгээд байдаг. Гэхдээ энэ бол 31 жил явж ирсэн уламжлал учраас бид тодорхой тооны цөөхөн хүнийг хүмүүсийг л орохыг нь зөвшөөрөөд яваад байгаа. Тэгэхдээ энийг нэмэгдүүлж болохгүй.

Харин энэ хэдийгээ иргэний бүртгэлийг бол бид нар 2011 оны бид нарын оруулсан хуулиар бол иргэний бүртгэл харин орж ирж Сонгуулийн хороонд орж ирснээр маш олон хэрэг маргаан бол цөөрсөн байгаа. Жишээлбэл ажил явуулахад амар болсон. Цагдаагийн даргын асуудал дээр ч гэсэн хэрэг маргаан зөрчилтэй асуудал дээр бол Сонгуулийн ерөнхий хороо асуудал шийдэж байгаа учраас энд орж байгаа нь бас зөв зүйтэй л болчихоод байгаа юм. Тэгэхээр энийгээ нэг тийм зөв зүйтэй

ойлгуулж ингээд яахгүй бол өнөөдрийн юмыг харангуутаа л эд нар чинь дандаа албан тушаалаар оруулдаг болчих вий, шууд сонсгол хийдэггүй болчих вий гэж. Угаасаа албан тушаалаар орж байгааг нь хуульчилж чадаж гэмээ нь тэгвэл тэрийг нь сонсгол хийхгүйгээр явуулдаггүй байх нь бол зөв. Тэгэхдээ энэ бол тодорхой.../минут дуусав/

Н.Энхболд: Баярлалаа. Одоохон, 2011 онд Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт ороод, 2010 оноос эхлээд 12 оноос эхлээд бид нар сонгуулийн шат шатын байгууллагад ажиллаж байгаа ажиллах хүмүүсийг төрийн албан хаагчдаас томилж ажиллуулдаг ийм болсон, дэг журам их сайн сайжирсан. Тэрнээс өмнө хаа хамаагүй хүмүүсийг сонгуулийн хороо хэсэг дээр томилчихоор сүүлд нь ямар ч хариуцлага хүлээдэггүй, сонгуулийн дүн гаргалгүй хаяад явчихдаг, гарсан дүнг аваад зугтаачихдаг ийм юмнууд хүртэл гарч байсан. Тэгээд нөгөө хүмүүстээ ямар нэгэн байдлаар хариуцлага тооцох төвөгтэй. Тэгээд хэд хэдэн удаагийн сонгуулийн туршилага энэ зүйлүүдээсээ сургамж аваад, ер нь төрийн албан хаагчид илүү хариуцлагатай ажиллах юм байна гэдэг агуулгаар ажиллах ёстой гэдэг агуулгаар одоо бол шат шатын сонгуульд төрийн албан хаагчид хэсэг, тойргууд дээр ингээд ажиллаад явж байгаа. Хуучинтай харьцуулахад болбол үр дүн нь их өөр, сахилга хариуцлага тооцох тал дээр, сонгуулийн дүн маргаангүй болох тал дээр бол ахиц сонгуулиас сонгууль тутам гарч байгаа гэдгийг 1 дүгээрт хэлэх хэрэгтэй байна.

2-т Сүхбаатар даргатай бол санал ерөнхийдөө нэг байна. Энэ одоо манай СЕХ болбол нэлээн тийм биеэ даасан бас тодорхой шийдвэрүүдийг өөрөө гаргадаг ийм байгууллага болж байгаа. Ялангуяа энэ Улс төрийн намуудын тухай хуулийг Үндсэн хуулийн агуулгад нийцүүлж шинэчилснээс хойш СЕХ-ны үүрэг хариуцлага болбол их хэмжээгээр нэмэгдсэн. Энэтэй нь

холбогдуулж бид нар түрүү түрүүчийн хурлуудаар ярьж байгаад энэ байгууллагын орон тоо, гүйцэтгэх үүрэг хариуцлагад нь бас тодорхой өөрчлөлтүүд оруулчихсан байж байгаа. Энэ нь ингээд явж байгаа гэдгийг хэлэх байна. Ер нь болбол ер нь бүрэн утгаараа л том бүрэлдэхүүн дотроо тэр биеэ даасан, хараат бус хэсэг нь давамгайлсан ийм харьцаатай байх ёстой гэдэг дээр болбол олон гишүүд бас ярьдаг, санал нийлдэг юм байна лээ гэдгийг хэлчихье. Доржханд гишүүн микрофоныг нь өгөөрэй.

Т.Доржханд: Баярлалаа.

Тэгэхлээр 2024 оны сонгууль бол маш их өөр сонгууль болно. Чухал сонгууль болно. Яагаад вэ гээд тэгэхээр энэ холимог системээр явж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шал өөр дүрмээр бид нар сонгуулиа хийх гэж байгаа. 76 гишүүн сонгодог байсан бол 126 гишүүн сонгоно. Тэгээд Үндсэн хуультай өөрчлөлттэй холбоотойгоор Улс төрийн намын тухай хууль өөрчлөгдсөн, Сонгуулийн тухай хууль өөрчлөгдсөн. Тэгээд энэ ажил маань өөрөө маш их тийм том ажил байгаад байна. Өмнөхөөсөө илүү. Юугаараа вэ гэхээр мэдээлэл өгөх хэрэгтэй байна иргэдэд. Хөдөө орон нутгаар явахаар сумнуудаар явахлаар иргэд мэдээлэлгүй байна. Ямар дүрмээр, яаж сонголтоо хийх юм бүү мэд тийм. Тэгэхээр энэ ажлыг хийхийн тулд энэ СЕХ-ны гишүүдийг бол яаравчлан ингээд томилоод ажилд нь оруулахыг бол дэмжиж байна.

Гэхдээ асуулт байна. Асуулт нь юу байна гээд тэгэхээр энэ чинь бүгдээрээ ингээд төрийн албан хаагч байна гээд хууль дээрээ, дүрэм дээрээ ингээд тусгачихсан байж байхад яагаад өнөөдөр төрийн албан хаагч биш хүн тэнд СЕХ-ны гишүүнээр ажиллаж байгаа юм бэ? Бүүр тов тодорхой дурдах юм бол Ц.Байгалмаа гэж хүн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга хийж байсан ийм хүн

байна. Гэтэл энэ хүн бол одоо хүртэл ингээд ажлаа хийгээд явж байх шиг байна. Гэтэл энэ хүн чинь одоо төрийн албан хаагч мөн юм уу нэг. 2 дугаарт надад ирж байгаа мэдээллээр энэ хүн чинь ял шийтгэл авсан байна шүү дээ. Анхан шатын шүүхийн шийдвэр гарсан байна, ял шийтгэл авсан байна хоёр. 3 дугаарт Хөгжлийн банкны нээлттэй сонсголын үеэр энэ хүний асуудал орж ирсэн шүү дээ. Иргэд бүгдээрээ мэдээлэлтэй болсон. Нотлох баримтын хүрээнд Халтмаагийн Баттулгын өмнөөс Монголын ардчилсан холбооны байрыг зарсан, хуурамч гарын үсэг зурсан гээд. Ингээд ийм олон зөрчилтэй хүнийг яагаад хүртэл ажиглуулаад байгаа юм бэ, солиоч, хуулиа бариач. Тэгээд үүн дээр бас тодорхой хариулт авмаар байна, тэгээд үгээ хэлмээр байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Түрүүн бид нар хэлсэн. Өнөөдөр бол 2 хүний асуудал оруулж ирж байна. Энэ хоёулаа яг төрийн тодорхой байгууллагуудыг удирдаж, сонгуулийн ажилд нэлээд их эрх, үүрэгтэй оролцдог ийм 2 байгууллагын асуудал. Энэтэй холбогдуулаад СЕХ-ны гишүүдийг албан тушаалаар зарим нь шууд автоматаар сольж байх тухай саналууд хүртэл сая гишүүдээс гарсан. УБЕГ, ЦЕГ болбол сонгуульд маш том үүрэгтэй оролцдог. Зөвхөн манайд ч биш юм байна лээ. Саяхан бид нар энэ Бельгийн Брюссель хотод болсон сонгуулийг яаж орчин үед цахим эрин үед сонгуулийг дэгтэй журамтай, амгалан тайван явуулах вэ гэдэг олон улсын том бага хурал болсон. НҮБ-аас зохион байгуулсан. Энэ дээрээс ярьж байгаа илтгэлүүд бусад орнуудад учирч байгаа асуудлууд бүх юмтай харьцуулаад үзэхэд жишээ нь бүртгэлийн байгууллага, цагдаагийн байгууллага 2 болбол нэлээн том эрхтэй орж байх ийм нөхцөл байдал бусад улс орнуудад ч байдаг юм байна. Цаашдаа энэ талаар ч бодох ёстой юмнууд их байдаг юм байна лээ. Энд нэг ийм зүйл хэлчихье. Өнөөдрийн 2 хүний хувьд

болбол яг энэ 2 байгууллагын хүн орж байгаа.

Ерөнхийлөгчийн Тамгын газраас буюу Ерөнхийлөгчийн зүгээс нэрийг нь дэвшүүлсэн хүний хувьд одоогоор манайд 1 дүгээрт Ерөнхийлөгчийн Тамгын газраас ямар нэгэн санал ирээгүй байна. 2-т хуулийн заалтууд түрүүн бас Доржханд гишүүнийг орж ирэхээс өмнө бид нар энэ талаас яриа хөндөгдөж гарсан. Ямар тохиолдолд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох вэ гэхээр энэ хуулийн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6.3-д хорооны гишүүн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөх хүсэлтээ өөрөө гаргасан болбол үүрэгт ажлаас нь чөлөөлнө. 6.5-д хорооны гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол энэ өдрөөс эхлэн түүнийг хорооны гишүүнээс огцруулсанд тооцно гэж байгаа юм. Хуулийн яг энэ 2 заалт нь байж байгаа юм. Бид нар бол бас Доржханд гишүүнтэй адилхан тийм мэдээллүүд байгаа. Тэгээд энэний дагуу шүүхэд хандсан, холбогдох шүүхийн байгууллагад нь хандсан. Шүүхийн байгууллагаас ирсэн тодорхойлолтод болбол энэ хүн анхан шатын шүүхээр ял авсан. Дараа нь Өршөөлийн хуульд хамрагдсан. Тэгээд давж заалдах шатад хэрэг нь явж байгаа учраас хэрэг нь эцэслэн шийдэгдээгүй байна гэсэн агуулгатай ийм бичиг ирсэн байж байгаа.

Тэгэхээр яг нөгөө хуульд заасан үг нь 6.5 дээр гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоод, тэгээд шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон болбол огцруулсанд тооцно, автоматаар огцруулсанд тооцно гээд биччихсэн байж байгаа. Тийм учраас өнөөдөр жишээ нь Байнгын хорооноос юм уу эсхүл Ерөнхийлөгчийн Тамгын газраас яг энэ хуулийн үг үсгийг дагахаар тэр шүүхийн тогтоол нь хүчин төгөлдөр болохыг нь

хүлээхээс өөр ийм аргагүй л байдал орчихоод байж байгаа юм. Ер нь зүгээр тэнд ажиллах СЕХ-ны гишүүний хүлээн зөвшөөрөгдөх байдал тийм ээ, тэр бүх талаас нь тал талаас нь хараад үзвэл хэрэг шийтгэгдсэн байдал энэ тэрийг нь хараад үзвэл жишээ нь Доржханд гишүүн ийм санал гаргахаас өөр аргагүй л байгаа л даа. Энийг ойлгож байгаа.

Энэний хажуугаар бас зарим гишүүдийн асуудлаар бид нар холбогдох байгууллагуудад нь хандаж үзсэн. Тэр нь юу вэ гэхээр СЕХ-ны гишүүнийг анх нэр дэвшүүлэхдээ төрийн жинхэнэ албан хаагчдаас гэсэн заалттай. Тэгээд дандаа тухайн үед төрийн жинхэнэ албан хаагч байсан хүмүүсийг энэ албан тушаалд нэр дэвшүүлж сонгож ирсэн. Энэний цаад логик утга нь 1 дүгээрт, 2 дугаарт 12 оноос эхлээд л Сонгуулийн жишээ нь хороо тойргийн тойрог, хэсгүүд дээр дан төрийн албан хаагч ажиллуулж байгаа энэ логик талаар нь аваад үзвэл бас Доржханд гишүүн ийм асуулт асууж, санал гаргахаас өөр аргагүй л нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгээд өнөөдрийн байдлаар яг энэ хуулиудын хүрээнд, энэ хуулиудын яг үг үсгийг нь хөөгөөд ингээд үзэхээр Байнгын хорооноос юм уу эсхүл Ерөнхийлөгчийн Тамгын газраас тэр нэр дэвшүүлсэн хүнийхээ оронд нь өөр хүн дэвшүүлэх ийм хуулийн гарц нь байхгүй байгаа юм. Эсвэл хуульдаа өөрчлөлт оруулах эсхүл тэр жишээ нь саяын нэр дурдсан Байгальмаа гэж гишүүнээс эсхүл өөрийнх нь хүсэлтийг авах, эсхүл Шүүхийн тогтоол нь эцэслэж хүчин төгөлдөр болохыг нь хүлээх ийм байдалтай л байгаад байгаа юм. Тийм.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгье. Үг хэлчихсэн үү, тийм билүү? Яах вэ энэ чухал асуудал. Доржханд гишүүн, Сүхбаатар гишүүн хоёрт, та хоёр товчхон 1, 1 минутад үг хэлчхээрэй. Доржханд гишүүн 1, 1 минут.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр Энхболд даргаа энэ дээр нөгөө бид нар ТББХ хуулиа дагамаар байна. 1 дүгээрт энэ Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга гэдэг чинь төрийн жинхэнэ албан хаагч биш, энэ улс төрийн албан тушаалтан шүү дээ тийм биз дээ нэг. 2 дугаарт тэгвэл энэ хүн маань өнөөдөр ажил хийж байгаа юу? 20 жилийн өмнө энэ хүн тухайлбал төрийн албан хаагч байсан юм. Тийм болохоор хуулийн гарц байхгүй байна гэмээргүй байна. Яагаад вэ гэхээр энэ чинь түүнээс хойш 5, 6 жил өнгөрсөн байна. Өнөөдөр энэ хүн бол төрийн жинхэнэ албан хаагч биш юм. 3 дугаарт анхан шатын шүүхийн шийдвэрээр ялагдагчаар татаад тэгээд шүүхийн шийдвэр гарсан байна шүү дээ. Тэгээд түүнийг нь бол Ерөнхийлөгчийн бичгээр түүнийг нь ингээд amnesty үзүүлсэн байна шүү дээ. Чөлөөлчихсөн байна шүү дээ. Тэгээд энэ бол аль хэдийн анхан шатын шийдвэр ингээд гарчихсан байхад энэ асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй байх. Тэгээд миний байр суурь бол юу вэ гээд тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хорооноос Ерөнхийлөгчийн Тамгын газар руу бол албан ёсоор.../минут дуусав/

Н.Энхболд: Ойлголоо. Доржханд гишүүн албан ёсоор 2 шалтгааныг нь үндэслээд 1 дүгээрт төрийн албан хаагч биш болсон байна, 2-т тэр нь нөгөө төрийн албан хаагчаас нэр дэвшүүлнэ гэдэгтэй логик уяатайгаар яваад, 2-т ялаа бол шийтгүүлчихсэн юм байна гэдэг утгаар нь холбогдох газарт хандаач гэдэг ийм хүсэлт гаргаж байна. Энэний дагуу Байнгын хороо бас үргэлжлүүлээд хандаж болно. Энэ дээр бид нар анхааръя. Сүхбаатар гишүүн 1 минут товчхон.

Ж.Сүхбаатар: Энэ юу вэ гэхээр зэрэг энэ төрийн албаараа ер нь тойрог, хэсгийн хороодыг бүрдүүлье гэдэг анх философийг 11 онд би Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байхад Бат-Үүл гишүүн гаргаад, тэгээд би энийг нь дэмжээд явсан, энэ нь зөв юм

байна гэж үзсэн. Тэр төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгож тэр нэг хэдэн албан тушаалтныг явуулж байгаа чинь Цэцтэй адилхан байхгүй юу. Одоо бид нар Цэцийн гишүүнийг явуулчихаад Их Хурал өөрчлөгдөхөөр буцаад татдаггүй шүү дээ. Тэр үеийн нэр дэвшүүлэх процессыг илүү бие даасан сонголттой институт төлөөлөх үүднээс нь явуулж байгаа болохоос биш тэр институцынх нь хугацаа дуусаад, хүн нь өөрчлөгдвөл шууд солино гэсэн утгаар бол хийгээгүй юм. Энийг би өөрөө хийж, томъёолж батлуулсан учраас энийг нь бас ойлгох хэрэгтэй. Харин тэр ял шийтгүүлчихсэн бол огцуулсанд тооцох тухай боломж бол байгаа л гэж бодож байна.

Н.Энхболд: Баярлалаа гишүүд санал хэлж дууслаа. Тогтоолын төслөө баталъя. Түрүүн би уншаад танилцуулчихсан. Сонсголыг 1 сарын, 24 оны 1 сарын 2-ны өдөр зохион байгуулахаар, асуулт нэр дэвшигчдэд хандаж асуулт асуух саналыг энэ оны 12 сарын 28-ны өдрийг хүлээн авахаар, өдрийг хүртэл хүлээн авахаар, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарыг томилох тухай ийм агуулгатай тогтоолын төсөл түрүүн бүрэн эхээр нь уншиж танилцуулсан. Ингээд энэ тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 28 хүртэл. Сонсголоо, тийм сонсголоо 2-нд бид нар хийнэ. Наана нь болбол гаднаас авах юмнууд нь байгаа. Тийм. Санал хураалтад 10 гишүүн оролцож, 8 нь дэмжиж, 66,7 хувиар Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжлээ. Энэ чинь Их Хурал. 1 дүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа. Гишүүддээ баярлалаа.

12.45 цаг

Хоёр.Хэвлэл мэдээллийн зөвлөлийн мэдээлэл сонсох.

Дараагийн асуудалдаа оръё. Түрүүн би хэлсэн. Сэтгүүлчдийн асуудлаар байгууллагынх нь мэдээллийг

сонсох. ТББХ-нд хандаж Хэвлэл мэдээллийн зөвлөл гэж байгууллагаас хүсэлт ирсэн. Санал солилцох хүсэлт. Тэгээд өнөөдөр бид нар ямар ч байсан тэр байгууллагын удирдлагыг дуудаад, ямар үйл ажиллагаа явуулдаг юм, ямар бэрхшээлүүд байгаа юм, ямар эрх зүйн зохицуулалт дээр юу анхаарах ёстой байгаа вэ, хамтарч ажиллах ямар боломжууд байна вэ гэдэг талаар мэдээллийг нь сонсьё гэсэн юм. Ингээд оролцох хүмүүсийг урьчихъя, нэрсийг нь өгчих. Би хуралдаанд оролцож байгаа хүмүүсийг танилцуулъя. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Гүнжидмаа босоод өөрсдийгөө танилцуулаад байгаарай. Төслийн зохицуулагч Болормаа, Удирдах зөвлөлийн дарга Тамир, Удирдах зөвлөлийн гишүүн Отгонбаяр. Ийм 4 бүсгүй өнөөдөр манай ТББХ-ны хуралдаанд оролцож байгууллагынхаа талаар мэдээлэл мэдээлэл хийх гэж байна. Ингээд хэн нь вэ? Гүнжидмаа дарга уу? Гүнжидмаа захирал энэ ХМЗ гэдэг байгууллагын талаар ямар үйл ажиллагаа явуулдаг, салбарт байгаа асуудлууд, танай зөвлөлийн зүгээс хийж байгаа ажил, энэ хооронд ямар нэгэн байдлаар эрх зүйн зохицуулалтад нь асуудал байдаг болбол түүн дээр ямар саналтай байдаг, хамтарч ажиллах ямар боломжууд байгаа талаар танилцуулгаа хийнэ. ТББХ-гоор хэлэлцэж байгаа шалтгаан нь манай Их Хурлын тухай хуулийн ТББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хэвлэлийн хараат бус байдлын тухай асуудал харьяалагдаж явдаг учраас та бүхний хүсэлтийг хүлээж аваад өнөөдөр сонсголыг чинь сонсох гээд бид нар байж байгаа юм. Ингээд 2 номерын микрофон өгье. Гүнжидмаа ХМЗ-ийн гүйцэтгэх захирал.

Г.Гүнжидмаа: Сайн байцаана уу? Та бүхэнд цаг заваа гарган биднийг бас хүлээн авч сонсож байгаад баярлалаа. Тэгээд хэвлэл мэдээллийн салбар маань өөрөө бас их өргөн олон талын тоглогч нартай бас ардчилалд нэлээн чухал үүрэг гүйцэтгэж явдаг ийм

салбар байгаа. Нийгмийн бас л бусад улс нөгөө салбаруудын нэгэн адил бас хөгжиж байгаа, олон саад бэрхшээл бас туулж байгаа. Энэ хүрээнд хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн асуудал маш чухал юм. Ёс зүйн үүрэг хариуцлагаа хүлээдэг, олон нийтийнхээ өмнө хүлээдэг, тайлагнадаг энэ системийг бол үүсгэн байгуулж, хөгжүүлэх ёстой гэдэг энэ санаачилга нэлээн эртнээс яригдсан. Тэгээд 2015 оноос онд бол байгуулагдсан байгаа.

Тэгээд ХМЗ гэдэг бол хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн өөрийн зохицуулалтыг хийж байгаа НҮТББ. Зөвхөн хэвлэл мэдээллийн салбарын төдийгүй нөгөө талд нь олон нийтийн эрх ашгийг хангаж хамгаалж бас ажилладаг ийм онцлогтой. Тэгэхээр 50 хувь дээрээ бид нар сэтгүүл зүйн асуудлыг хөнддөг, ёс зүйтэй, чанартай байх тал дээр нь, 50 хувь дээр нь бол олон нийтийн эрх ашиг мэдэх, үнэнийг мэдэх эрх, олон нийтийн эрх ашгийн төлөө ингэж ажилладаг ийм дундын байгууллага байгаа. Юуг нь дар. Бид нар Монгол Улсын хувьд ардчилалд олон чухал индексүүд нөлөөлдгийн нэг чухал үзүүлэлт бол хэвлэлийн эрх чөлөөний индекс ямар байхаас нэлээн их хамаардаг. Ингээд 2015 онд Монголын хэвлэл мэдээллийн салбарынхан салбарын өөрийн зохицуулалтын байгууллагатай болсон. Тэр нь бол тухайн үеийн хэвлэл мэдээлэлд бол түүх болоод үлдсэн. 2015 оны 1 дүгээр сард байгуулагдаж байсан, одоо 9 жил болж байгаа. Тэгээд энэ 2015 онд хэвлэлийн эрх чөлөөний индекс 180 орноос 54-д жагсааж байсан. Тэгээд гол шалтгааныг бас энэ хэвлэлийн салбар өөрөө өөрийгөө зохицуулах энэ тогтолцоо механизмтайгаа болсон юм гэдгийг бол бас онцолж энэ индексэд нөлөөлж байсан.

Тэгэхээр өнөөдөр бид нар энэ индексийн тоо бол 180 орноос 88 хавьд явж байгаа. Тодорхой хэмжээгээр бид нар бас ухралтууд гарч байна. Тэр нь шалтгааныг энэ хэвлэл мэдээллийн

хараат бус байдлыг бэхжүүлэх, дээр нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эрх чөлөөг хангах талын эрх зүйн зохицуулалтууд бас олон янз гарч байна. Тэр нь бас үр дүнтэй оновчтой байж чадахгүй байна. Хэвлэл мэдээлэлд тавих нөгөө цензур нэмэгдэж байна эд нар гэдэг энэ шалтгаануудыг бас олон улсын тэр индексийн байгууллагууд бол тэмдэглэсэн байдаг. Бид нар салбар дотроо мэдээж энэ ёс зүйн хариуцлагыг өөрийн зохицуулалтаар хийхийн төлөө маш их хичээн ажиллаж байгаа. Энэ салбарт бол 400 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагад 5 мянга орчим хүн ажилладаг. Түүнийх нь 2 мянга орчим нь бол энэ салбарын идэвхтэй буюу сэтгүүлчид, уран бүтээлчид, найруулагч зэрэг хүмүүс байдаг. Тэгэхээр энэ хүмүүсийн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмийг нь бол батлаад түүнтэй холбоотойгоор иргэд, олон нийтээс гомдол хүлээж авч шийдвэрлэх, энэ шүүхээс өмнөх шатад шийдвэрлэх энэ үйл ажиллагааг хийж байгаа. Тэгээд энэ гомдлын дүнгээс харахад бол ихэвчлэн нөгөө мэргэжлийн суурь үйл ажиллагаагаа чанаржуулах шаардлага бол их харагддаг. Хамгийн их зөрчигддөг кодууд бол ёс зүйн кодын 1.1, 1.2 зэрэг мэдээллийг нөгөө илүү их баталгаатай найдвартай байдлаар хангаж, олон нийтэд хүргэх, олон талын мэдээллийн эх сурвалжуудтай байх зэрэг ч юм уу.

Тэгэхээр бид нар энэ тал руу бас сэтгүүлчдийг чадавхжуулах, сургах, бэхжүүлэх талд бол тасралтгүй үйл ажиллагаагаа сүүлийн 8 жилийн хугацаанд явуулж байгаа. Дараагийнх нь, ерөнхийдөө ирсэн өргөдөл гомдлыг харахаар энэ механизм ажиллаж чадах юм уу үгүй юү гэдэг асуулт бол 10 жилийн өмнө байсан. Энэ механизмд бол олон нийт оролцоноороо л эргэлдүүлж чаддаг. Тэгэхээр 2015 онд бид нар байгуулагдсаныхаа дараа 19 иргэнээс гомдол санал хүлээж авч байсан бол жилдээ нэг дунджаар 80-аас 100 гомдол санал хүлээж авч, түүнийг нь бол Ёс зүйн

хороодоороо хэлэлцэн шийдвэрлэж байна. Энэ хэмжээний одоо 500 гаруй өргөдөл гомдлыг бид нар олон нийтийн эрх ашгийг хангахын төлөө шийдэж байна гэдэг маань шүүхэд тэр хэмжээний ачааллыг бол бууруулсан гэж үзэж байгаа.

Яагаад гэвэл хэвлэлийн өөрийн зохицуулалт ажиллаагүй тохиолдолд энэ их гомдлууд бол шүүх, прокурор, цагдаа зэрэг төрийн байгууллагуудад бол ачаалал болж очно. Мөн энэ гомдлуудыг шийдвэрлэхэд буцаагаад ХМЗ-тэй санал нийлэхгүй байна гэсэн маргаан бол гараагүй. Тэгэхээр тодорхой хэмжээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрхэн хийж байгаа дээр нь болбол салбарын зүгээс бол үндэслэлтэй дүгнэлт зөвлөмж өгч байна гэж бас харагдаад байгаа юм. Ихэнх гомдлууд бол сонин сэтгүүл сайтын ёс зүйн хороонд ирдэг. Нөгөө хороо нь бол Радио, телевизийн ёс зүйн хороонд харьцангуй бага. Тэгэхээр манай оронд бол цахим сайтууд маш ихээр нэмэгдсэн, үйл ажиллагаа нь идэвхжиж байгаа. Энэ бол бас л улс бусад улс орнуудын нэгэн адил хөгжлийн үе шаттай л явж байгаа зүйл. Тэгээд ялангуяа цахим орчинд сошиал медиа энд илүү их тэлж, хөгжих болсноороо мэргэжлийн сэтгүүл зүй нь аль нь юм, яг энгийн иргэдийн сошиал медиа дээрээ мэдээллээ хуваалцаж байгаа, үзэл бодлоо илэрхийлж байгаа энэ орон зай нь аль нь юм бэ гэдэг энэ ялгаа маш их бүдгэрсэн. Үүнээс болж худал ташаа мэдээлэл, болохгүй, бүтэхгүй сошиал медиа дээр явж байгаа бүх зүйлийг сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхэн хийсэн мэтээр бол нийгэм харж байдаг.

Яг статистик тоог харахад хэвлэл мэдээллийнхэн өөрсдөө ёс зүйн дүрмээ баримталж, ёс зүйтэй байхын төлөө бас хичээж байна. Дээр нь прокурор, хууль хүчний байгууллагад ирсэн статистик тоог харахад болбол Эрүүгийн хуулийн 13.14-өөр гомдол гаргасан тооны 10 орчим хувь нь энэ сэтгүүлч редакцад хамаарч, бусад хувь

90 хувь нь иргэн хоорондын маргаан байгаад байгаа юм. Тэгэхээр энэ сошиал медиа дээр байгаа 3 сая иргэний мэдээлэл солилцох, хуваалцах, үзэл бодлоо эрэлхийлэх энэ эрх чөлөөг илүү их тийм мөн л ёс зүйн хэм хэмжээтэй, илүү тийм иргэдээ боловсруулах тал руу бид нар хандахгүй болбол энд ардчиллын нөгөө суурь болсон хэвлэлийн эрх чөлөө нөгөө мэргэжлийн сэтгүүл зүй болбол энд ингээд живчих ийм эрсдэл бас харагдаад байгаа.

Тэгэхээр өчигдөрхөн НҮБ-ын зүгээс санаачилга гаргаж бүх улс орнуудад энэ сошиал медиа, дижитал платформ дээр байгаа иргэдийн үзэл бодлоо илэрхийлж байгаа энэ эрх чөлөөг хангах замаар энийгээ ёс зүйтэй илүү илэрхийлдэг болох тал руу бүх нийтийн уриалга гаргаж байна лээ. Тэгэхээр энэ талд бас манай улс орон анхаарч ажиллах байх гэж харж байгаа. Харин 2 мянган хүн ажилладаг энэ сэтгүүлчдийн орон зай бол Хэвлэлийн зөвлөл өөрөө энэ гомдлыг нь хүлээж аваад чанаржуулаад, ёс зүйтэй явуулах бүрэн боломжтой юм гэдэг энэ жишиг бол бусад дэлхийн улс орнуудын хөгжлийг харсан ч манайд бас энэ бол бас үр дүнгээ өгч байгаа харагдаж байгаа. Гомдол гол гаргагч нар болбол ХМЗ-д дийлэнх нь жирийн иргэд байдаг бол шүүхэд хандаж байгаа гомдол гаргагчдын дийлэнх нь нөлөө бүхий албан тушаалтнууд байгаад байдаг. Тэгэхээр ХМЗ-д ч гэсэн сүүлийн жилүүдэд улс төрч, төрийн албан хаагч, төрийн байгууллагууд гомдол гаргах энэ хандлага бол бас нэмэгдэж байгааг бол сайшааж харж байгаа. Гэхдээ энийг бол илүү цаашаагаа редакц болоод иргэнд сэтгүүлчийн бүтээлтэй холбоотой гомдлыг ХМЗ рүү ирдэг энэ механизм тогтолцоог бүр бодлогын түвшинд бас илүү дэмжиж, бэхжүүлэх эрх зүйн хувьд нь ч гэсэндээ энэ замыг илүү нээж өгснөөрөө бид нар хэвлэлийн эрх чөлөөнд ээлтэйгээр ёс зүй хариуцлагыг бол тооцох бүрэн боломжтой гэж харагдаж байгаа.

Дараагийнх, бид нар бас өнгөрсөн 15-аас 20 онд хийсэн бүх 500 гаруй өргөдөл гомдол дээр дүн шинжилгээ хийгээд, ямар алдаа хэвлэл мэдээллийн салбарт илүү байгаа юм бэ гэдгийг нэг тоймлон харуулсан энэ слайдаар би мэдээллээ өндөрлөө. Энэ дээр бол илүү их тийм мэргэжлийн редакцуудад хандсан зөвлөмжүүд бас байгаа. Нягтлан шалгах энгийн дүрмээ баримтлах хэрэгтэй байна. Хэвлэлийн бага хурал бол эх сурвалж байдаг байсан бол биш болж байна. Эрэн сурвалжлах бүтээл бичихэд энд бол гол гомдогч нар маш ихээр гарч ирж байна. Энэ нь буцаад нөгөө шударга ёс, хариуцлага, авлига хээл хахуулийн талаар хэвлэл мэдээлэл хөндөөд ирэхэд л шүүх рүү ч гомдол гаргадаг, ХМЗ рүү ч гомдол гаргадаг бүх талын энэ шалгах ажиллагаа эхэлдэг. Энэ байдал бас манайд ирж байгаа гомдлуудаас харагдаж байгаа. Тэгэхдээ бас энэ салбарт өөрөө эерэг хандлага, эерэг зүйл бас явж байна. Энэ нь салбарын өөрийн зохицуулалтаараа алдаагаа засаад, олон нийтийн өмнө уучлалт гуйдаг залруулга гаргадаг энэ жишиг рүү болбол энэ салбар өөрөө эргэчихсэн байгаа, маш их өөрчлөлтүүдийг харуулж байгаа. Тэгэхээр бас энэ эерэг хандлага зүйлийг бол илүү их дэмжээд ажиллах ажиллаасай гэж бас харж байгаа.

Тэгээд мөн сэтгүүлчдийг бүтээл нийтэлснийх нь төлөө давхар яллах хүсэлтэй гомдогчид бол нэлээн байгаад байдаг нь гомдол гаргагч тал Хэвлэлийн зөвлөл болоод шүүх хоёрыг бол хамт ашиглаад байгаа нь яг салбарт ажиллаж байгаа сэтгүүлчид болоод редакцынханд бол нэлээн их хүндрэл болж байгаа гэдгийг бас манай хамт ирсэн хүмүүс бас хэлэх байх. Тэгээд миний мэдээлэл ингээд өндөрлөөд, би хамт байгаа хүмүүсээ манай удирдах зөвлөлийн дарга Тамир, манай удирдах зөвлөлийн гишүүн Зууны мэдээ сонины ерөнхий эрхлэгч Отгонбаяр нар бас төлөөлөл болоод орж ирсэн. Нэмж мэдээлэл хэлэх байх гэж хүсээж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Хэд дээр сууж байна вэ Отгонбаяр, микрофон 4 байна уу? 4 номерын микрофон. Нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд.

Д.Отгонбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би ХМЗ.../үг тасрав/

Н.Энхболд: Дуулдахгүй байна.

Д.Отгонбаяр: ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Отгонбаяр.

Н.Энхболд: Дуулдахгүй байна Отгонбаяраа. Микрофоноо ойртуулж байгаад.

Д.Отгонбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Би Зууны мэдээ сонин эрхлэгч ХМЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Отгонбаяр. ХМЗ гэдэг энэ байгууллага нь өөрөө Монгол Улсын хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа сэтгүүлчдийн ёс зүйтэй холбоотой асуудлыг хариуцаж ажиллаж байсан 2015 оноос хойш. Өнгөрсөн энэ хугацаанд ажиллаж ирсэн туршлага, үр дүнгээс харах юм болбол ХМЗ нь өөрөө салбартаа хүлээн зөвшөөрөгдөөд, салбартаа хүлээн зөвшөөрөгдөж байгаа гэдэг нь ХМЗ-д ирж байгаа гомдлыг эсрэг гомдол гаргаж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагууд байхгүй. ХМЗ-д гомдол гарсан тохиолдолд редакцууд тайлбараа хуулийн хугацаанд нь өгдөг. Нөгөө дүрэм журмынхаа хугацаанд нь өгдөг. Ёс зүйн хороод нь дүгнэлтийг гаргаад, гарсан дүгнэлтээ хэвлэл мэдээллийн байгууллагуудад хүргээд, тэрийгээ олон нийтэд хүргээдэг ингээд тогтсон ийм жишиг нь бол ингээд их аятайхан бий болоод явчихсан байж байгаа.

ХМЗ бол төрийн бус байгууллага. Өдий хүртэл явж ирсэн ХМЗ-ийн явж ирж байгаа санхүүгийн эх үүсвэр болбол хэвлэл мэдээллийн байгууллагуудын өөрсдийнх нь дэмжлэг. Бид өөрсдөө ХМЗ-өө дэмжлээ гээд ингээд редакцууд нэгдээд тодорхой хэмжээний бага

хэмжээний дэмжлэгийг ХМЗ-дөө ишилжүүлдэг. Гэхдээ энэ бол хангалтгүй байгаа бөгөөд хангалтгүй байгаа. Нөгөө талаараа ХМЗ өдий хүртэл ажиллаж ирж байгаа юун дээрээ туршилага дээрээ олон улсын байгууллагуудтай нягт хамтарч ажиллаж ирж байгаа. Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийг үндсэндээ хэрэгжүүлж бас ажиллаж байгаа нь энэ байгууллагын оршин тогтох нэг үндэс болж байгаа. Цаашидаа бол энэ байдлаараа хэвлэл мэдээллийн ХМЗ дандаа олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрт дулдуйдаж явах уу, яаж явах вэ гэдэг бол бас бидний хувьд бол анхаарах, гарц гаргалгаа хайх ёстой ийм асуудал болж байгаа.

Хэдийгээр хэвлэл мэдээллийн байгууллагууд ХМЗ-өө дэмжиж ажиллаж байгаа ч гэсэн энэ байгууллагынхаа үйл ажиллагааг цаашидаа тогтвортой аваад явах хэмжээнд болбол редакц, хэмжээнд бол хүрэхгүй байгаа. Редакциуд маань өөрсдөө бас тийм их хангалттай хэмжээний санхүүгийн хувьд тогтвортой биш байгаа гэх мэтчилэн олон зүйл нөлөөлж байгаа. Энэ дээр бол бас төрийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, хэвлэлийн эрх чөлөөг дэмжихдээ ХМЗ гэдэг энэ байгууллагаар дамжуулан хэвлэлийн эрх чөлөөг хангахад дэмжлэг үзүүлэх боломж байна гэж бид нар бол хардаг. ХМЗ-ийн нөгөө нэг бидний яг өдөр тутамд энд ажиллаж байгаа салбарт ажиллаж байгаа хүмүүст дэм болж байгаа гэх юм уу, бидний ажилд урагш ахиц авчирч байгаа гэж хэлж болж байгаа энэ редакцын соёлуудад нөлөөлж байгаа нэг юм бол гомдол, тухайн гомдлыг ХМЗ-д гаргахдаа тухайн иргэн юм уу, сэтгүүлчид хандаж гаргадаггүй. Редакцад гомдол гаргадаг. Редакц өөрөө хариуцлагаа хүлээх ёстой гэдэг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн заалтыг бол энд бол маш сайн хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Редакцад хандаж байгаа гомдлын хариуцлагыг редакц өөрөө хүлээнэ. Редакц өөрөө гарч байгаа нийтлэл нэвтрүүлгийнхээ хариуцлагыг хүлээх гээд ингээд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг үйл ажиллагаандаа хариуцлагатай хандахад бол энэ байгууллага маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа байгууллага. Тэгэхээр миний ХМЗ-ийг байгуулж байх явцад одоо манай энэ олон улсын байгууллагуудын зөвлөх туршилага бид нарт бас зөвлөгөө өгч байгаа энэ байгууллагууд Дойче Велле гэх мэт байгууллагуудын жишигээс харах юм бол ХМЗ-ийг жишигээр Герман улсад 49 хувийн санхүүжилтийн дэмжлэгийг төрийн байгууллагаас үл тайлагнах журмаар дэмжлэг үзүүлдэг гээд. Энэ нь ардчиллын суурь зарчмыг бэхжүүлэх дэмжих гэдэг хүрээнд дэмжлэг олгодог юм байна лээ. Тэгэхээр энэ ХМЗ гэдэг байгууллагыг бол төрийн байгууллагын зүгээс дэмжихэд бас тийм гарц гаргалгаа, хууль, эрх зүйн хүрээнд ямар байдаг юм бэ гэдгийг бас та бүхэн анхаарч, анхааралдаа авч үзээч гэж гэдгийг саналаа хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Энхболд: Товчхон, товчхон, 3 номер. Асууна дараа нь тийм.

У.Тамир: Манай хүмүүсийн хэлсэн юман дээр яах вэ товчхон нэмээд хэлчихэд манайд энэ ХМЗ өөрөө ардчилал хөгжссөн орнуудад яг хэвлэлийн зохицуулалтыг бол энэ аргаар хийгээд ингээд туршилага олон жилийн олон зуу гаруй жилийн туршилагатай яг бид нар Европын холбооны энэ туршилага дээр үндэслэж хэвлэлийн эрх чөлөөнд халтайгаар биш тэгэхдээ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан яг тийм сайн жишигээр хийсэн байгаа. Тэгээд өнгөрсөн жил бид нар Данийн хөндлөнгийн шинжээчээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд үнэлэлт өгүүлсэн. Тэр үнэлэлт дүгнэлтээс ингээд харах юм бол яг өнөөдрийн түвшинд ХМЗ хэвлэл мэдээллийн салбартаа бол хүлээн зөвшөөрөгдсөн байна. Илүү нөгөө талын

50 хувь болох олон нийт, иргэдэд энэ Хэвлэлийн зөвлөлийн ач тус, яаж ажилладаг гэдгийг илүү ойлгуулах ёстой гэсэн зөвлөмж бид нарт өгсөн.

Тэрний дагуу мэдээж та бүхэн төрийн төр засгийн Их Хурлын гишүүд бас энэ талаар ойлголттой байж бид нарын ажил бас ингээд зөв тал руугаа явна гэж ингэж харж байгаа. Түүнчлэн өнгөрсөн жил бид нар Европын Холбоонд очиж энэ Монгол Улсад ХМЗ-ийг хэрхэн байгуулж яаж төлөвшүүлж байгаа туршилагаа бид нарыг ярихыг хүссэн. Бид нар очиж яриад тэнд бол сайн жишиг болсон байна. Ялангуяа экссосоциалист орнууд буюу зүүн Европын орнуудад Хэвлэлийн зөвлөлийг байгуулах оролдлого ерөөсөө бүтэлтэй болохгүй байгаа. Танай сайн жишигийг сайн нөгөө бест практикаар болгож болгоё гэсэн ийм юуг бол тавьсан байгаа. Тэгэхээр ингэж сайн төлөвшиж байгаа юуг нийгмийн хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж, ойлгуулж, ингээд цаашид дэмжлэг авч явах нь бид нарт чухал байгаад байгаа юм. Тэгээд сая ярилаа нөгөө ихэнхдээ ингээд цагдаа, шүүхэд бол мэдээж гомдлууд бол гарч байгаа сэтгүүлчтэй, редакцтай холбоотой. Гэхдээ тэр гомдлуудын яг шийдвэрлэлтийг эргээд харахаар мэдээж хэвлэлээр юм уу, сошиалаар сүр дуулиантай чимээгээр ингээд шүүхэд өглөө, цагдаад өглөө, ингээд явж байна гэдэг. Гэвч яг эцэстээ шийдэгдсэн хэрэг хэд вэ гэхээр маш цөөхөн байдаг.

Гэтэл ХМЗ одоо өнөөдөр иргэдээс ямар ч үнэ төлбөргүйгээр гомдлыг нь аваад тэгээд тэр гомдлоо бол 3 сарын хугацааны дотор улиралдаа нэг удаа хуралддаг Ёс зүйн хороогоороо мэргэжлийн дүгнэлт гаргаад, тэрийгээ олон нийтэд зарладаг. Мэдээж зарладаг механизм маань бол бас манайд төдийлөн сайн явж чадахгүй байгаа. Энэ нь бас мэдээж нөгөө санхүүжилттэйгээ тодорхой хэмжээгээр холбоотой байгаад байгаа. Тэгээд санхүүжилтийн хувьд бид нар бас яах вэ ер нь хараат бус

бие даасан байх ёстой гэж үзэж байгаа учраас тэрийгээ хангахын тулд бид нар бас нэг ийм иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагыг хүлээнэ, хэвлэлийн эрх чөлөөг ёс зүйтэй, хариуцлагатай хэвлэл мэдээллийг дэмжиж байгаа бол та бүхэн бид нарыг нийгмийн хариуцлагынхаа нэг хэсэг болгооч гэдэг уриалгыг гаргаад бас нэг ийм төрийн бус байгуулах ажлыг бас эхлээд явж байгаа.

Нөгөө талдаа нэг юм хэлэхэд мэдээж ёс зүйтэй хэвлэл явахын тулд эрх зүйн орчин мэдээж бид нарт аягүй чухал. Эрх зүйн орчин нь бас өөрөө зөв байж, олон улсын жишигээрээ явж байж энэ 2 хосолж байж хэвлэл мэдээллийн салбар өөрөө эрүүлжих юм гэж бид нар харж байгаа учраас ХМЗ-д бас эрх зүйн өөрчлөлтөд нэлээн анхааралтай хандаж, үг үгээ илэрхийлж бас явдаг байгаа. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн өөрчлөлт магадгүй нөгөө гүтгэх доромжлох ингээд олон нийтийн юу билээ нэр төр халдах гэсэн янз бүрийн Иргэний хууль, Эрүүгийн хууль гээд гэмт хэрэгт тооцох энэ тэр гэсэн асуудлууд дээр бол бас үгээ хэлдэг. Бид нар бол энэ нь олон улсын жишигээр эрх зүйн орчин зөв байгаасай гэж ингэж боддог. Тийм учраас хууль тогтоогчид маань ямар нэгэн хуулийг хийхдээ энд бас нэг өөрийн зохицуулалтынх нь механизм ажиллаж байгаа юм шүү. Энэ механизмыг нь эхэлж авч үзэж байж, дараагийн шат нь шүүх рүү явах энэ процессыг бий болгох урьдчилал нөхцөл юу байж болох вэ гэдгийг та бүхэн хууль тогтоохдоо бас анхаарч үзээсэй гэж бид нар хүсээж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Өөр нэмэх хүн байна уу? Тэгвэл гишүүд асуулт асууя. Сонсгол юм чинь бид нар бас сонирхох, асуух зүйлүүд байна. Нэрсээ өгье гишүүдээ. Батсуурь гишүүнээр тасалъя. Би дараа нь асууна. Урьд нь гишүүд асуучихгүй бол давхардуулалгүйгээр. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би энэ ХМЗ ингээд хөгжлийнхөө шатад явааг бол ойлгож байна. Ардчилал бол өөрөө энэтэй холбоотой. Ёс зүйн асуудал ярьж байгаа юм. Одоо ингээд улс төрчдийн ёс зүйн асуудал. Ёс зүйн асуудлыг ярихын тулд нөгөө хүн нь ёс зүйн хувьд илүү давуу байдалд байх ёстой байдаг. Тухайн хүн бусдын ёс зүйг ярьж байгаа бол өөрөө давуу байдалд орох ёстой. Тэгэхээр энэ утгаараа болбол би ингээд ХМЗ-ийг ч гэсэн ингээд харахад сая 21-ээс 22 оны юмыг харахаар өргөдөл гомдлууд өгөхөд ихэвчлэн гомдол гаргагч нь буцаагаад татчихсан байгаа байхгүй юу. 25 нь гомдол үндэслэлгүй татчихсан. Тэгээд ингээд ярихаар би зүгээр ХМЗ ингээд ажиллаж байна. Тэгэхээр сэтгүүлчдийг та нар институт гэж үзээд байна шүү дээ. 4 дэх засаглал, би 4 дэх засаглал гэж бол яг томъёолоход бол санал нийлдэггүй хүн. Та нар засаглах институт гэж үзээд байна шүү дээ. Хууль тогтоох эрх мэдэлтэй, гүйцэтгэх, одоо бүүр нэг сэтгүүлч хэлсэн шүү дээ. Би засагламаар байна гэж. Засаглана гэдэг чинь захирна гэж хэлдэг гэсэн утгатай шүү дээ. Нөгөө power гэдэг үгийг чинь 2 салаа утгуудаар явдаг байхгүй юу. Power гэдэг чинь нэг нь эрх мэдэл буюу институт эрх мэдлийн институт гэж явдаг. Нөгөөдөх нь хүч нөлөө гэж явдаг байхгүй юу. Тэр утгаар нь хүч нөлөө гэдэг утгаараа ярина уу гэхээс биш засаглах институт гэж ойлгоод ирэхээрээ зэрэг руль булаацалдаад байна гэж судлаачид хэлээд байгаа байхгүй юу. Сайдын орон сайд болох гээд л, гишүүдийн оронд ингээд ингэж тэгж хий, ингэж хийхгүй бол чамайг ингэнэ гээд л руль булаацалдаад байгаа.

Тэгсэн хэр нь өөрсдөө хариуцлага хүлээхгүй. Энэ болохоор яах вэ, мэргэжлийн хүмүүс судлаачид сүүлийн үед ярьж байгаа зовлон гээд байгаа юм. Төрийн удирдлагад тохиолдож байгаа. Рулийг нь ингээд булаацалдаад байдаг. Өөрийгөө би ингэж засаглал, институт, тийм учраас би шийдвэр гаргах эрхтэй

гэдэг ийм агуулга руу. Тэгээд эсвэл нэг институт дотор зөрчилдөж байгаа бүлгүүдийн аль нэг талд нь ордог, ороод нөгөөдүүлийгээ үхтэл нь гүвдэг. Тэгэхээр яах вэ энэ ХМЗ-ийг би яавал хүчтэй болгох вэ гэж асуудал. Улс төрийн намууд дээр бол нэг ийм дүрэм байдаг юм. Мөнгийг нь бохир мөнгө улс төрийн нам дээр цутгаж байгаа юмыг нь л өөрчилж санхүүжилтийн схемийг нь л өөрчил гэдэг дүрэм явдаг. Тэрэн шиг хэвлэл мэдээллийг зарим нь засаглалынхаа институт гэж ойлгогчлоод, тэгээд санхүүжилтээ бусад институтүүдтэйгээ хамтарч босгоод, тэгээд ёс зүй, шударга ёсны урианы доор тэгсэн хэр нь санхүүгийн эх үүсвэр нь адилхан нэг эх үүсвэрээс өөрсдөө авдаг. Тэгчхээд нөгөөгөө чи тэр нь ийм байна гээд яваад байгаа байхгүй юу.

Тэгээд гомдол санал гарна гэхээр аягүй төвөгтэй. Өөрсдөө нэг эх үүсвэрээр л санхүүжиж байгаа байхгүй юу. Төрийн нийтийн мөнгөөр л аль аль нь санхүүжээд байгаа байхгүй юу. Гэтэл ХМЗ дээр ингээд харахад ёс зүйгээ баримтлахын тулд төрийн нийтийн хөрөнгөөс санхүүждэг хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн тоо ядаж редакц юм уу тэр байгууллага нь цөөрөх ёстой байхгүй юу өөрөө. Хэрвээ тэр нийтийн хөрөнгөөр санхүүждэг бол улс төрч Их Хурлын гишүүн надаас юугаараа ялгаатай юм. Би ч төсвөөс санхүүжиж байгаа шүү дээ. Тэр хүн ч төсвөөс санхүүжиж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тохиолдолд ёс зүйн асуудал ярихад аягүй төвөгтэй. Энэ Монголын нийгмийн чинь гол юм барьцалдчихсан байгаа шүү дээ. Сүхбаатараа чи ёс зүйгүй гээд л яриад байна хүн. Нөгөө хүнийг эргүүлээд л чи яаж цалингаа тавиад байгаа юм гээд л үзэхээр адилхан төсвөөс авчихсан. Эсвэл төсвийн хулгай ярьж байгаа бол тэр чинь төсвийн хүрээнд зөрчилтэй байна уу үгүй юү гээд л үзвэл ер нь бараг бүгд журмын хувьд бол бараг зөрчилтэй шүү дээ ер нь нарийн яривал.

Тэгэхээр энэ ийм үед ингээд гомдол, агуулга, ёс зүй ингээд ярина гэхээр ингээд яг үнэндээ бантан л байгаа байхгүй юу, адилхан. Тэгэхээр ХМЗ маань том утгаараа бол яах вэ сэтгүүлчийнхээ эрх ашгийг тодорхой хүн дээр хамгаалъя, нягтлан сайн шалгаач, хохирогчийгоо хамгаалъя эд нар гээд яриад байгаа боловч ерөөсөө явж, явж гол эх үүсвэр нь чи хэдээс хаанаас санхүүжээд байгаа юм гэдгээс бол. Би нийтийн хөрөнгөөс санхүүжиж байгаа учраас илүү их л хариуцлага түгээгээд л, ёс зүйн шаардлага тавиад л, шүүмжлүүлэх нь аргагүй болчихоод байгаа юм. Гэтэл нөгөө шүүмжилж байгаа этгээд нь адилхан төсвийн хөрөнгөөс адилхан надтайгаа адилхан санхүүжилт аваад явдаг байгаа нөхцөлд өөрөө ямар байх вэ гэдэг асуудал ер нь Монголын нийгмийн асуудал болчихоод байгаа байхгүй юу. Энэ ёс зүйн, ХМЗ ч гэсэн цаашаа өөрөө яаж хөгжих юм, санхүүгийнхээ эх үүсвэрийг яаж бүрдүүлэх юм, өөрөө яаж цаашид яаж амьд явах юм гэхээр энд л жинхэнэ асуулт, бодит асуудал байгаа юм. Энэ тал дээр юу гэж боддог вэ?

Н.Энхболд: Хэн нь хариулах вэ? 3 номер. Битгий дар, битгий дар. Наадах чинь цаанаасаа асна. 3 номер.

Г.Гүнжидмаа: ХМЗ-ийн санхүүжилт яг өнөөгийн байдлаар бол яах вэ ер нь бол бид нар хэвлэл мэдээллийн байгууллагуудаасаа санхүүжилт, хандив хүсдэг. Гэхдээ өнөөдрийн манай зардлын 10 орчим, 10 хүрэхгүй хувийг л хэвлэл мэдээллээс өгч байгаа багахан хэмжээний юу санхүүжилт байгаа. Бусад нь бол бид нар дандаа ингээд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар тэр төсөл хөтөлбөрийн менежментийн зардлаараа ажлын алба авч явж байгаа. Нөгөө талдаа Хэвлэлийн зөвлөл өөрөө 45 гишүүнтэй, 3 бүтцэд хуваагддаг, 15 хүн нь Удирдах зөвлөлд, 2 Ёс зүйн хороондоо 15, 15-аараа хуваагддаг. Энэ 45 гишүүн маань өнөөдөр цэвэр сайн дурын үндсэн дээрээ ямар ч цалин мөнгөгүй ингээд ажилладаг байгаа. Тэгээд энэ төлөөлөл

маань бүх нөгөө хэвлэл мэдээллийн төлөөлөл нөгөө талдаа эздийн төлөөлөл, сэтгүүлчдийн төлөөлөл, олон нийтийн төлөөлөл байдаг. Тухайлбал би өөрөө бол олон нийтийн төлөөлөл болчихсон ингээд явж байгаа хүн.

Тэгэхээр энэ олон талын оролцоог хангачихсан байгаа байдал маань бие биеийнхээ үйл ажиллагаанд огт оролцдоггүй. Ёс зүйн хороо гомдол хэлэлцээд шийдвэрлэж байхад Удирдах зөвлөл тэнд нөлөөлөх ямар ч нөлөөлөл байхгүй. Өөрөөр хэлбэл бид нар хараат бус байдлаа хангаж чадах тэр бүтцээ бий болгочихсон байгаа юм. Зүгээр санхүүжилт өнөөдөр угаасаа боломжгүй байгаа учраас бид нар тэр гомдол хүлээж аваад тэрийг нь нэг хэлэлцүүлдэг Ажлын албаны 3, 4-хөн ажилтныг, төсөл хэрэгжүүлж байгаа нэг хэдэн ажилтан бол төслөөрөө явчихдаг. Тэр 3, 4 хүнээ л цалинжуулах санхүүжилтээ бид нар төслөөс олж авч байгаа. Тэгэхээр бид нар энэ санхүү, өөрөө Хэвлэлийн зөвлөл дотортой байя, өөрийн чинь хэлж байгаа шиг өөр бусад юунаас хамааралгүйгээр хэвлэл мэдээллийн байгууллагуудаасаа ч хамааралгүй явъя гэвэл мэдээж хэвлэл мэдээллийн байгууллагуудаас өгч байгаа хандивыг авах, тийм ээ олон нийтээс авах, бизнес эрхлэгчдээс авах, магадгүй төр ч байж болно. Төр хэрвээ хүсээд дэмжвэл энэ олон талын санхүүжилт нь өөрөө ил тод нээлттэй, юунд зарцуулж байгаа, хэнээс хэдэн төгрөг ирж байгаа гэдэг юм байх ёстой. Гэхдээ бид нарын санхүүжилт зөвхөн Ёс зүйн хорооныхоо үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Бусад хүмүүст бол санхүүжилт гардаггүй байгаа. Ялгаа нь бол хэвлэлийн байгууллагуудаасаа ялгаатай нь бол нэг ийм ялгаатай байгаа юм.

Н.Энхболд: Товчхон, товчхон. 2 номерын микрофон.

Г.Гүнжидмаа: Ерөнхийдөө бас асуултыг би энэ редакчуудын санхүүжилттэй холбож бас ойлгосон.

Тэгэхээр энд 400, 500-аад хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа. Тэдгээрийн санхүүжилтийн асуудал бол бид нарт нөгөө оролцох, бид нарын эрх хэмжээний бол асуудал биш. Гэхдээ мэдээж яг ингэж төрийн хэвлэл мэдээллийн салбарт нэг тулгамдаж байгаа асуудал бол гол хөрөнгө оруулагч санхүүжүүлэгч нь төр өөрөө болоод хувирчихлаа гэдэг. Яг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар бол яг энэ бол хориотой шүү дээ тийм ээ, төр дэргэдээ хэвлэл мэдээллийн байгууллага ажиллуулж болохгүй, агуулгад нь ямар нэгэн хэлбэрээр цензур тогтоохгүй гээд. Тэгтэл өнөөдрийн, тийм учраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр дээр та бүхэн харсан байх. Яг энэ төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээлэлтэй хийж байгаа, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хийж байгаа бүх санхүүжилтийг ил тод болгох, шилэн байх тэр механизмыг болбол Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан байсан. Тэгэхээр энэ тал дээр хэвлэл мэдээллийн өөрийнх нь санхүүжилтийн ил тод байдал нэлээн сайжрах байх гэж харж байгаа.

Мэдээж яг ингээд ёс зүйг ярихын тулд хүн нь өөрөө ёс зүйтэй байх ёстой. Ёс зүйг би нөгөө очоод ярихын тулд тэнд байгаа редакц өөрөө бас тийм ээ нөгөө юун ёс зүйтэй манатай байж бас болохгүй болчихож байгаа. Яг энэ бэрхшээл бол мэдээж бид нар туулж байгаа зам. Тэгэхдээ бид нарт сайн жишгүүдийг болбол тавьж үлгэр болох зүйлүүдээ бид нар хийж явах ёстой гэж хардаг. Тийм учраас өнөөдөр бид нар редакцын ажлын ар талд юу болдог юм бэ гэдгийг олон нийт, уншигчдад танилцуулах редакцын буухиа хүртэл гээд хөдөлгөөн өрнүүлж байна. Мэргэжлийн редакцын хийсэн ажил, сошиал медиа дээр яваад байгаа мэдээллээс чинь юугаараа ялгаатай юм, танд нэг ийм сонин нүүр материал очихын тулд тэрний ард ямар их хөдөлмөр явдаг юм бэ гэдгийг бид нар

олон нийтэд ойлгуулах маш чухал байгаа. Тэгэхээр энэ бол олон нийтийн ойлголтыг мэдлэгийг дээшлүүлэх ажил, редакцууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдөө санхүүгийн зөв модельтой болж хөгжих асуудал, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, энэ ёс зүйтэй холбоотой гомдлыг нь шийддэг байх энэ олон янзын асуудлууд тал талдаа л өрнөж байна. Тэгээд бас үр дүн харуулах байх л гэж итгэж, найдаж байгаа. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа.
Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа.
Тэгэхээр яах вэ манайд бол хэвлэл мэдээллийн салбар зохицуулалт багатай, тэгээд л ер нь өрсөлдөөний зарчмаар л яваад байгаа нэг ийм зүйл. Тэгээд ёс зүй, хариуцлага эд нар гээд яривал бас асуудлууд их л бий. Тэгэхээр би бол энэ ХМЗ-ийг энэ салбарын зохицуулалтыг хийх чиглэлтэй байгууллага юм байна гэж ойлгож байна та бүгдийн мэдээллээс. Тэгэхээр энийг эрх зүйн хүрээнд нь ер нь цаашидаа яаж гаргаж ирэх ёстой юм бэ, олон улсын зарчим нь ямар байдаг юм бэ? Бид энэ Хэвлэл мэдээллийн хуульдаа өөрчлөлт хийж, энийг гаргаж байж эрх зүйн хүрээнд нь ер нь ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм бэ гэдгийг 1 дүгээрт нь асууя гэж бодож байна.

2 дугаарт нь одоо манайд хамгийн замбараагүй юм бол энэ сошиал медиа байгаа юм. Нийгмийн сүлжээ. Хариуцлага байхгүй, ёс зүй байхгүй. Монгол Улсад 2,5 сая фэйсбүүк хаяг байна гэж байгаа юм. Тэрний 1,5 сая нь хуурамч байна гэж. Тэгээд энэ сошиал медиаг зохицуулах зайлиггүй шаардлага байна гээд Улсын Их Хурал өнгөрсөн жил хууль гаргасан юм л даа уул нь. Дэлхий нийт улс орнууд энэ сошиал медиагаа ямар нэгэн хэлбэрээр зохицуулалттай болгож байна. Дор хаяхад тэр нь хуурамч хаяггүй болгож байна. Тэгээд энэ талаар энэ ХМЗ ер нь ямар бодол,

сэтгэлтэй байдаг юм бэ гэдгийг би 2 дугаарт нь асууя гэж бодож байна.

3 дугаарт нь энэ хэвлэл мэдээллийн байгууллагууд одоо бол нэг сенсацын хойноос хөөцөлдсөн гол дуу болчихоод болохгүй байгаа юм. Тэр бид нарын дүгнэж байгаа шүү, би өрөөсгөл нэг талаас нь дүгнэж байгаа байж магадгүй. Уул нь болбол энэ миний ойлгож байгаагаар болбол аливаа асуудалд анализ дүгнэлт хийдэг, нийгмийг зөв зүйл рүү нь чиглүүлэх тэр гол түүчээ нь болох энэ чиглэл рүүгээ явдаг явах ёстой л гэж ойлгож байгаа. Энэ чиглэл рүү хэвлэл мэдээллийн байгууллага огт явахгүй байгаа. Орлогын хойноос хөөцөлдөөд л, зар сурталчилгаа, бизнес, тэгээд нөгөө энэ олон нийтийн сонирхдог ядуу мэдээлэл рүүгээ гол юмнуудаа явуулчхаж байгаа юм. Энэ чиглэлээр энэ ХМЗ-ийн баримтлах бодлого чиглэл нь ямар байна вэ?

4 дэх асуудал нь ерөөсөө хамгийн том юм бол иргэдийг соён гэгээрүүлэх асуудал байгаа юм. Иргэдийг соён гэгээрүүлэхэд энэ ХМЗ-ийн үүрэг би чухал гэж бодож байгаа юм. Тэгээд манайд энэ зохицуулалт байхгүйгээс болоод энэ соён гэгээрүүлэх үүргүүд ихэнх тохиолдолд орхигдоод байна. Тэгээд л нэг л мэдээний араас уралдаж, тэгээд нөгөө сенсацтай мэдээгээрээ хоол олж иддэг ийм л чиглэл нь гол гээд ойлгочихсон. Энийгээ өөрөө нөгөө 4 дэх засаглал гээд ингээд ойлгочихсон ийм юмнууд бол байна. Тэгэхээр би энэ ХМЗ-ийг ер нь цаашидаа эрх зүйн хүрээнд нь ямар хэмжээнд байх ёстой юм, тэрийг нь эрх зүйн хүрээнд нь яаж хуульчлах хэрэгтэй байна, олон улсын хэмжээнд ямар түвшинд байна вэ гэдгийг тодруулж байгаа юм. Баярлалаа.

Н.Энхболд: Хэн бэ? 2 номерын микрофон, Гүнжидмаа байна уу?

Г.Гүнжидмаа: Баярлалаа. 1 дүгээр асуулт эрх зүйн зохицуулалт. Ер нь эрх зүйт төрт нийгэмд бид нар хуулийн зохицуулалт, 2-т нь салбарын

өөрийн зохицуулалт. Хамт зэрэгцэн хөгжиж байж бид нарын зорьж байгаа зорилгодоо тууштай хурдан хүрнэ гэж хардаг. Тэгэхээр хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалт буюу бид нар ёс зүйтэй яг тэр бүтээлийнх нь чанарын хяналтыг бид нар тавьж байна гэсэн үг. Ингэснээрээ бид нар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд тусгасан төрөөс хэвлэл мэдээллийн агуулгад хяналт тавихгүй гэдэг тэр чиг үүргийг бид нар илүү хэрэгжүүлээд явж байна гэсэн үг. Нөгөө талд нь хууль, эрх зүйн орчин үнэхээр шаардлагатай хэрэгтэй, юу юуг бид нар хуулиар зохицуулах юм, юуг өөрийн зохицуулалтад нь үлдээх ёстой юм бэ гэдэг энэ бол салбарын хувьд байнгын хэлэлцүүлэг дунд байгаад байдаг. Жишээлбэл бид нар юу гэж хардаг вэ гэвэл Эрүүгийн хууль дээр хүнийг санаатайгаар гүтгэж доромжлоод болоогүй зүйлийг болсон мэтээр зохиогоод хор хохирол учруулсан бол энд гүтгэх юм. Энийг өөрийн зохицуулалт, ёс зүйгээр тогтоох боломжгүй. Яагаад гэвэл ёс зүйн өрийн зохицуулалт мөрдөн шалгах ажиллагаа хийхгүй, хэрэг бүртгэл нээхгүй, нотлох баримт цуглуулахгүй, хэзээ ч редакцыг дуудаж байцаалт авахгүй.

Тэгэхээр энэ зүйлүүдэд хуулийн хүрээнд зохицуулагдах ёстой. Харин мэргэжлийн үйл ажиллагаа явах үед аль ч мэргэжлийнхний хувьд алдаа гардаг. Тоо буруу тавихаас, дутуу бодохоос, цаг нартай уралдахаас, турилага дутахаас үүдээд гарч байгаа тэр алдаа болгоныг Эрүүгийн хуулиар явуулж болохгүй юм. Энэ бол өөрийн зохицуулалтыг хийх ёстой зүйл гэдэг энэ ялгаа заагууд дээр бид нар ойлголт нэг байх тохиолдолд хийх, хийх үүргүүд маань маш тодорхой гараад ирэх гээд байдаг. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль дээр бид нар зарчмын хэд хэдэн саналуудыг бол өгдөг. 1 дүгээрт хэвлэлийн эрх чөлөөнд сэтгүүлч редакц өөрөө нөгөө түрүүн бас хэлж байсан, засаглал юм уу гээд. Би энийг бол үүрэг нь хоточ банкны үүрэг буюу *watched up* хийх үүрэг гүйцэтгэдэг.

Тэр хүрээндээ сэтгүүлчид энийгээ би засаглаж байна гэж ойлгоод байвал энэ бол бас таашаа юм. Хяналт тавих бүх энэ нийгмийн институт бүрд хяналт тавих үүргээ сайн гүйцэтгэх ёстой. Тэр нь хамгийн чухал юм. Нөгөө мэдээллийг хайж олж авч, эрэн сурвалжлахаас эхэлдэг. Энэ үед хамгийн чухал юм чинь нөгөө эх сурвалжаа нууцлах эрх нь өнөөдрийг хүртэл Монгол Улс баталгаажсаагүй байгаа нь өөрөө энэ нухацтай асуудлууд руу сэтгүүлчдийг ороход тээг болоод байдаг.

Мөн сүүлийн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд дээр нэг энэ салбарыг цэгцтэй болгох ёстой юм байна. Тэгэхийн тулд хэн нэгэнд нэг мэдэл өгөх юм уу, нэгийг нь ингээд хуульд оруулаад өгчих юм байна. Тэр нь хэн бэ гэж хайж байгаад ХМЗ гээд бичигдчихсэн. Тэгтэл ХМЗ чинь өөрөө хуулиас гадуур бие дааж ажил үйл ажиллагаа явуулах ёстой, хууль дотор яг тэр байгууллагын дүрэм журам, бүтэц, үүрэг, чиг үүргийг заагаад ирэхэд энэ бол өөрөө төрийн зохицуулалт болно. Ихэнх Азийн орнууд бол хэвлэл мэдээллээ төрийн зохицуулалтаар хийж байгаа бол Европын орнууд өөрийн зохицуулалтаар илүү явж байна. Хөгжиж байгаа улс орнууд хөлөө олох гээд л ядаж явна. Яг Монголтой адилхан Гүрж, Босни эд нар гээд. Нэг бол төр нь орж ирчих гээд л нөгөө болбол өөрсдөө явах гэхээрээ уначих гээд л нэг ийм дөнгөн данган явж байгаа. Тэгэхээр би Монгол Улс өөрөө энэ жишгээрээ Төв Ази болоод Зүүн Европын орнуудад сайн жишиг болоод 10 жил болж байгаа юм чинь бид нар энийг нэг тал талаасаа дэмнээд хараат бусаар яг үүргээ гүйцэтгэдэг тийм нэг институт болгочих юм сан гэж зориод яваад байдаг.

Яг хэвлэлийн өөрийн зохицуулалтыг 3 түвшинд дэмжлэг гэдэг юм. Улс төрийн түвшинд дэмжлэг хэрэгтэй, бодлогын дэмжлэг хэрэгтэй. Тэр нь яагаад гэвэл шүүх рүү тэр явж

байгаа айлган сүрдүүлэх, дарамт учруулах зорилготой тэр хэрэг.../минут дуусав/

Н.Энхболд: Дараа нь гүйцээ хариулчхаарай. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Миний сая 2 асуух гэж байсан асуултыг маань Тогтохсүрэн дарга асуучихлаа. Ер нь эрх зүйн хүрээнд яаж ажиллах ёстой юм бэ гээд. Үнэхээр хэвлэл мэдээллийн салбар 4 дэх засаглал уу гэвэл 4 дэх засаглал. Би яагаад үүнтэй санал нийлдэг вэ гэвэл өөрөө сэтгүүлч хүн учраас бид нийгэмд үзүүлэх нөлөөлөл, төр засгийн гаргаж байгаа шийдвэрт бас тодорхой хэмжээний нөлөөлөл, үр дүн, дүгнэлт хийх тэр боломжийг нь хэвлэл мэдээллийн байгууллага олгодог учраас бид нар 4 дэх засаглал уу гэвэл 4 дэх засаглал. Гэхдээ бид нар өнөөдөр 4 дэх засаглалынхаа үүргийг ер нь хэр биелүүлж байна вэ гэдэг дээр дүгнэлт хийх ёстой гэдэг зүйлийг би хэлэх гэсэн юм. Яагаад гэвэл өнөөдөр бид 4 дэх засаглалынхаа эрх, үүргийн хүрээнд нийгэмд нөлөөлж байгаа нөлөөллийнхөө тэр үр дүнг судалж үздэг үү? Тийм ээ. Бид энэ мэдээллийг олон нийтэд хүргээд энэ олон нийтэд хүргэсэн мэдээлэл маань олон нийт хэрхэн хүлээж авч байгаа юм. Эргээд магадгүй засаг төр шийдвэр гаргахдаа энэ асуудлыг тусгаж уу үгүй юу гэдэг дээр судалгаа хийсэн тийм юм байдаг юм болов уу?

Би яагаад ийм судалгааг бас асуугаад байна вэ гэвэл өнөөдөр социал орчин давамгай байгаа энэ цаг мөчид хэвлэл мэдээлэл өөрийн редакцын бодлогын хүрээнд хүлээсэн үүргийнхээ хүрээнд ёс зүйн хүрээнд энэ нийгмийг зөв чигт нь чиглүүлэх тэр үүргээ хэрхэн яаж биелүүлж байна вэ гэдэг дээр бас нэг судалгаа хийгээсэй гэсэн ийм хүсэлт байгаа юм. Өнөөдөр сая Монгол Улс фэйсбүүкийн хэрэглээгээрээ Азидаа тэргүүлдэг гээд сая Тогтохсүрэн дарга хэлчихлээ. Үнэхээр ийм давуу байдалтай

ийм нөхцөлд сайтууд гэдэг юм уу тийм ээ, бие даасан үйл ажиллагаа явуулж байгаа сэтгүүлч нар маань яг энэ зөвлөлийн ХМЗ-ийн гишүүн нь байж, үүргээ хүлээж, эрхээ эдлэхийн дагуу үүргээ хүлээж байна уу үгүй юу гэдэг дээр та бүхэн өөрсдөө бас дүгнэлт хийж үзсэн үү? Би яагаад ингэж асуугаад байна вэ гэвэл өнөөдрийн маань сэтгүүлчдийн буруутай, буруугүй гэдэг энэ гомдол санал шүүх дээр очиж байгаа энэ нөхцөл байдлаас харах юм бол та бүхний хамтын ажиллагаа хэр байна вэ гэдгийг л асуух гэсэн юм.

Өнөөдөр сэтгүүлчид маань аливаа мэдээллийг тэнцвэртэйгээр мэдээлэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх тэр эрхийг нь эдлэхийнхээ сацуу нийгэмд хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой байдаг. Гэтэл сэтгүүлчийн өөрийнх нь хувь хүний гэдэг юм уу үзэл бодлоос илүүтэйгээр тэр мэдээллийг л олон нийт хүсэж байгаа болохоос биш үзэл бодлоо тулгах энэ нөхцөл байдал илүү давамгайл болсон нь нийгэмд нөлөөлөөд байгаа юм биш үү л гэж би хараад байгаа юм нэг ийм асуулт. Өнөөдөр түрүүн хэллээ л дээ. Төрийн ямар нэгэн санхүүжилт бидэнд хэрэгтэй байна гэж. Хэрвээ Үндэсний олон нийтийн радио, телевизийг төрөөс санхүүжүүлж байгаа гэдэг энэ байдлаас шалтгаалан төр олон нийтийн тархийг угаахын тулд Үндэсний олон нийтийн телевиз, радиод нөлөөлөөд байна гэдэ ийм хардлага олон нийтийн дунд байгаад байдаг. Тэгвэл энэ санхүүжилтийг нээлттэй болгох зайлшгүй шаардлага байгаа юу гэвэл байгаа.

Цаашидаа үнэхээр бид арилжааны гэдэг юм уу тийм ээ, чөлөөт зах зээлийн зарчмаараа өөрсдөө мөнгөө олоод явах гэтэл нөгөө л хаалтын гэрээний асуудал ярьдаг. Хэзээ ч хэвлэл мэдээллийн байгууллага хаалтын гэрээ гэж хийдэггүй, хамтын ажиллагааны хамтран ажиллах гэрээ л гэж хийдэг шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ дээр бас сэтгүүлчдээ хамгаалах тал дээр зөвлөл

ер нь юу хийдэг вэ, хийж байна вэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм би. Яагаад гэвэл сэтгүүлчдийн нэр хүнд өнөөдөр ямар хэмжээнд байгаад байгаа юм бэ? Бид сэтгүүлчдээ хамгаалах тал дээр Сэтгүүлчийн нэгдсэн эвлэл ХМЗ-д маань ажиллаж чадаж байна уу үгүй юу? Үнэхээр зөвхөн ёс зүйн асуудлыг хариуцдаг болбол энэ дээр бид яах ёстой юм бэ? Харж байна тийм ээ, та бүхэн маань үнэхээр сэтгэл зүрхээрээ ажиллаж байгаад хүлээн зөвшөөрөх ёстой бид нар, талархах ёстой бид нар, хамтрах ёстой та бүхэнтэй. Гэхдээ хэрхэн яаж гэдэг энэ санал та бүхэнд байна уу үгүй юу гэдгийг би сонсох гэсэн юм. Хэрвээ үнэхээр тийм санал байгаа бол дэмжээд явах боломж бас бидэнд байгаа гэдгийг бас хэлье.

Н.Энхболд: Баярлалаа.
Гүнжидмаа 2.

Г.Гүнжидмаа: Эрх зүйн хувьд бид нарын зүгээс ХМЗ-өөс нэг л зүйлийг бол хүсдэг. Тэр нь сэтгүүлчийн редакцын эсрэг гаргаж байгаа ёс зүйн хүрээнд шийдэж болох асуудлыг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар шийддэг энэ замыг л эрх зүйн хувьд баталгаажуулаад өгөх. Ингэхэд бол төрийн ачаалал ч маш, шүүх прокурорын ачаалал ч маш зөв аятайхан болно. Дээр нь Монгол Улс хэвлэлийн эрх чөлөөний индекс нь ч хамаагүй дээшилнэ. Бид нар салбар дотроо ёс зүйн хүрээнийхээ асуудлуудыг шийдээд хэрэгжүүлээд явах боломжтой. Нэг л ийм өгүүлбэр гэж байгаа юм. Гагцхүү энэ өгүүлбэр нь цаашиа явахаараа нэг бүлэг болж задраад байгаа нь маш аюултай. Бүлэг болж задрахаараа бид нар өөрийн зохицуулалт биш, хараат бус зохицуулалт биш төрийн зохицуулалт руу орчих гээд байгаа энэ эрсдэл бас байгаад байгаа юм. Тэрийг бас та бүхнийг ойлгож аваасай гэж хүсэж байгаа.

2-т нь тэр санхүүжилтийн хувьд бол бид нар иүүд одоо бол мөнгө

гуйгаагүй. Тэгээд өнөөдөр ХМЗ өөрийн хэмжээнд нөгөө олон улсын хөтөлбөрүүд, өөрийн редакцуудын дэмжлэгээр тодорхой хэмжээнд бол аягүй ахиц дэвшилтэй ажиллаж байгаа. Ирээдүйд магадгүй бид нарын хувьд олон нийтийн дэмжлэгийг гүйцэтгэх дэмжигч байгууллага гэдэг энэ шинэ соёлыг бас бид нар эхлүүлж байна. Тэр нь бол энэний нийгэм нь магадгүй ёс зүйтэй хэвлэл байж, ёс зүйтэй бизнес ч, ёс зүйтэй улс төр бүх юм энэнд хамаарна. Тийм учраас хамтаараа энэ оролцох энэ талбарыг бид нар хөгжүүлж байгаа. Тэгэхээр энэ талбар маань хэр явахыг харъя. Ялангуяа тэр түрүүн Отгонбаяр эрхлэгчийн хэлсэн жишиг болбол өндөр хөгжчихсөн байгаа орнуудад иргэний мэдэх эрхийг хангаж байгаа шүүхийн ачааллыг бууруулж байгаа гэдэг үндэслэлээр ямар ч нөхцөл тулгахгүйгээр хараат бус байдалд нь нөлөөлөхгүйгээр төр өөрийн үүргээ биелүүлж, дэмжлэг үзүүлдэг энэ жишиг бол байгаа. Энэ хүрэх хүртэл манайд хэр хугацаа зарцуулахыг мэдэхгүй. Өнөөдөр бид нар мөнгө яриад л эхлэх юм бол энэ өөрөө бүүр нөгөө гуйвуулга болоод явчихдаг учраас би энийг энд орхиё гэж бодож байна.

Сошиал медиатай холбоотой түрүүний асуудлууд дээр редакцууд болбол ёс зүйн дүрэмтэй юм. ХМЗ бүх редакцууд руу тойрч явж байна, бид нар редакц энийг мөрдөнө гэдэг гарын үсэг цуглуулж явж байна. Тэгэхээр энэ өөрөө ингээд хандлага явж байгаа. Сошиал медиа дээр байгаа хүмүүс чинь дүрэмгүй тоглогчид юм. Энэ хоёрыг битгий нийлүүлж хууль, эрх зүйн орчин хийхдээ ч битгий нийлүүлж бод, асуудлыг ялгаж харахдаа ч гэсэндээ энэ сэтгүүл зүй болбол өөрөө энэ тусдаа дүрэмтэй, журамтай, зохицуулалттай энэ салбар юм гэдгийг харж, нөгөө дүрэмгүй байгаа хэсгээ ялгаж харахгүй болбол энэ маань бид нарыг ерөөсөө нөгөө итгэх итгэлийг маш их унагаж байгаа. Хэвлэл мэдээллийн салбарт итгэх итгэл байхгүй, шүүхэд итгэх итгэл байхгүй,

парламентад итгэх итгэл байхгүй. Бид нар энэ итгэлгүйгээр цаашаагаа яаж явах юм бэ гэдэг чинь манай салбарын ч гэсэн тулгамдсан асуудал. Тийм учраас бид нар өнгөрсөн жилийн форуммаа эрх чөлөөгөө хадгалж, итгэлийг олж авъя гэдэг сэдвийн дор 100 орчим хэвлэлийнхнийг оролцуулж хийсэн.

Хамтын ажиллагааны хувьд мэдээж бид нар салбар өөрөө олон тоглогч нартай, бие даасан, хараат бус ажиллах ёстой. Редакцын аль ч бодлогод бид нар нөлөөлөх учиргүй. Гэхдээ бид нарын хамтын ажиллагаа бол идэвхжиж байгаа, хамтдаа зөв зам руу явж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Н.Энхболд: Жаргалмаа гишүүн 1 минут.

Б.Жаргалмаа: Саяын яг санхүүжилтийн асуудал тийм ээ, одоо редакцгүй чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллага, чөлөөт сэтгүүл зүй энэ маань өөрөө нийгэмд ямар нөхцөл байдалтай байгаа билээ. Яг өнөөдөр албан ёсны редакцууд хэвлэл мэдээллийн байгууллагууд маань олон нийтэд рүү чиглэсэн таны итгээж болох эх сурвалж чинь энэ юм. Таны мэдээллийг дүгнэлт хийх эрхийг энэ редакц өгнө тийм ээ, мэргэжлийн ёс зүйн асуудлыг энэ редакц өөрсдөө хариуцна гэдэг юм уу энэ нөлөөллийн ажил бас жоохон хийгээч гэж би хүсмээр байгаа юм. Тэгэхгүй бол олон нийт чинь нөгөө сошиалаа дагаад л, үнэхээр итгээж болох эх сурвалж мөн үү үгүй юү гэдэг итгэл нь байхгүй болчихоод байгаа учраас та хэдийг тэр чиглэл рүүгээ ажиллаач, бүхий л боломжоор дэмжих боломж байгаа шүү гэдгийг л хэлээд байгаа юм. Баярлалаа. Хуулийн тэр зүйл, заалтыг ч гэсэн оруулаад ирэх юм болбол бид нар дэмжээд явах бүрэн боломж байгаа шүү. Баярлалаа.

Н.Энхболд: Жаргалмаа гишүүн үг хэлсэн. Оюунчимэг гишүүн асууя.

М.Оюунчимэг: Манай энэ ХМЗ сая Гүнжидмаа захирал, Тамираа, Отгонбаяр маань гээд л ер нь зүтгээд л байгааг харж байгаа. Тэгээд бас жоохон хүч дутаад байна л даа 1 дүгээрт. 2-т эрх зүйн болоод санхүүгийн тал дээр одоогоор тогтоогүй, бүтэцгүй байгаад байна шүү дээ. Анх бас яаж байгуулагдсаныг ч бид нар мэднэ. Тэгээд сая хэлж байна л даа, сошиал медиа гэж медиа гэнгүүт хүмүүс олон нийтийн сүлжээг хэвлэл мэдээлэл гэж андуураад харин яг редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага маань энэ сошиалд орон зайгаа бараг тавьж өгөхөд хүрчхээд байна шүү дээ одоо. Гэтэл сошиалд чинь бол ажилтай, ажилгүй, малчин, тариачин ер нь хэн ч орж болно. Нүүрээрээ ч орж байна, нүүрээ нуугаад ч орж байна. Тэгээд тэр нь өнөөдөр энэ хэвлэл мэдээллийн орон зай юм шиг, бүгд сошиал руу ингээд хуйлраад, энэ Монголын нийгмийг үнэхээр буруу чиглүүлж байна шүү дээ. Уг нь бол редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага бол оюун санааны чиглүүлэгч, улс орны уг нь хөгжлийн бодлогын бодлого ёстой бие дагаад ингээд нөлөөлдөг байсан гэдэг шүү дээ. Дээр үед жишээ нь Тонишуул гээд л яаж их нөлөөлдөг байсан билээ. Би бас Үндэсний олон нийтийн радио, телевизэд ажиллаж байх үед ч гэсэн бид нар бараг Их Хурлын гишүүдээс илүүтэй хэлэлцэх гэж байгаа хуулийг нь уншчихаад, энэ дотор чинь ийм юм явж байгаа юм байна шүү дээ, энэ нь асуудалтай юм байна, энэ дэмжвэл улс оронд хэрэгтэй юм байна ч гэдэг юм уу тэгээд маш тийм анализ хийж, материалаа уншиж тэгээд ордог байсан бол одоо яг үнэнийг хэлэхэд тийм сэтгүүлч бараг цөөхөн болчихоод байна шүү дээ. Байхгүй болоод байна. Одоо яг ирж байгаа энэ, эд нарын ч буруу биш.

Яагаад гэвэл сургалт гээд нэг хэдхэн сарын сургалтад явчихсан, тэгээд 1 яг аль сургууль яасан нь мэдэгдэхгүй. Тэгээд энэ хүмүүсийг хөөрхий нөгөө редакцгүй, редакц нь юм уу захирал нь эсвэл бодлогоор сургалтад явуулах юм

байхгүй. Бид нарыг чинь бас ВВС гээд л Тамир мэдэх байх. Хэвлэл мэдээллийн, Хэвлэлийн хүрээлэн энэ тэрээс олон сургалт зарлаад л бид нар CV-гээ бөглөөд л, шалгараад л Голланд ингээд л Герман гээд зөндөө явдаг байсан бол одоо тэр байхгүй болчихоод байна. Тэгэхээр өнөөдөр бас энэ ТББХ, ХМЗ-ийн үйл ажиллагааны тайланг сонсож байгаа нь өөрөө үнэхээр нэг том дэвшил. Тэгээд харин бүгдээрээ 1 дүгээрт ийм мэргэжлийн, бодлогын юм ярьдаг. Саяын Тогтохсүрэн гишүүний ярьдаг аналитик тийм сэтгүүлчдийг бэлдэх, тэрэн дээр төрийн дэмжлэг хэрэгтэй санхүүгийн.

2 дугаарт нь ХМЗ үнэхээр том түвшинд ажиллая гэвэл бас төрийн дэмжлэгтэй, өөрсдөө бас нөгөө төрөөс ангид байх гэж яриад байгаа юм. Гэтэл төр гэдэг бол улс орны хөгжлийн асуудал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн асуудал. Жишээ нь эрүүл мэнд, боловсрол гэдэг юм уу бас энэ чинь нэг өөр шүү дээ. Идэж ууж байгаа юм уу, буруу юманд холбогдсон дарга нарыг хамгаалах биш харин зөв юм руу орж байгаа тэр зөв төрийн бодлогыг нь дэмжээд, тэнд нь анализ хийгээд явчихдаг, олон нийтэд зөв мэдээлэл хүргэчихдэг, оюун санааны чиглүүлэгч байх үүрэг нь өөрөө өнөөдөр уг нь их чухал байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тал дээрээ бүгдээрээ сайн хамтарч ажиллахгүй бол өнөөдөр ХМЗ-ийн би бас тайланг уншсан. Сая та бүхнийхээ ярьж байснаас харж байхад голчлон гомдол дээр л хамаг цаг чинь яваад байна шүү дээ. Энэ бидний зорилго гээд л аваад үзэхэд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих, сэтгүүл зүйн салбарт мэргэжлийн болон ёс зүйн хэмжээг дэвшүүлэх, хараат бус байдлыг хамгаалах гээд л том зорилт байгаа хэр нь энэ дээр та нарын нөлөө үнэхээр бага байгаад байна.

Редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага ч бид нар сайн дэмжиж чадахгүй. Одоо сонинуудыг хар өдөр тутмын. Олон нийтийн радио, телевиз

Ийгл арилжааны хэр нь бас сайн явуулж байгаа телевизүүд энэ тэр гээд л үзэхэд үнэнийг хэлэхэд аль нэг улс төрийн юм уу, бизнесийн бүлэглэлийн дэмжлэггүйгээр өөрсдөө бие даагаад явахад үнэхээр амаргүй болчихсон байгаад байна шүү дээ. Тэр бүлэглэл рүү орчихоор л өөрөө нөгөө хэвлэл мэдээллийн эрх чөлөө, ёс зүйн хэм хэмжээ гэдэг чинь байхгүй болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр бүгдээрээ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиа ХМЗ-ийг ажиллах эрх зүйн орчин дээр, санхүүжилтийн механизм энэ тэр дээр хамтдаа сууж байгаад нэг одоо л нэг чиглүүлэхгүй бол энэ салбар үнэхээр хүнд байдалд орлоо шүү дээ. Тийм учраас бид нар өнөөдөр энэ хэлэлцэж байгаагийн үндсэн дээр нэг хамтраад бодлогын нэг юм гаргачихвал их чухал байна.

Н.Энхболд: Тэгье, 1 минут Оюунчимэг гишүүнд өгчихье, саналаа хэлж байгаа юм байна.

М.Оюунчимэг: Бид нар чинь бас нөгөө 1 дүгээрт Хэвлэлийн хүрээлэнгээс энэ олон улсын сургалтууд, 2 дугаарт сэтгүүлчдийн клуб гээд нөгөө эдийн засгаар, бизнесээр, улс төрөөр, хуулиар гээд дагнасан клубүүд байгуулаад, тэд нарыгаа бас бодлогоороо дэмжээд сургалтад хамруулаад ирээд яг нөгөө хэвлэл мэдээллийн салбарын мундгууд ингээд бэлдэж байгаа шүү дээ. Манай Отгонбаяр бол яг өдөр тутмын сонины маш том тоймч хүн шүү дээ, мундаг бичдэг. Гэтэл дараа дараагийн үеэ бэлдэх хэрэгтэй болоод байдаг. Ялангуяа сонины сайн тоймчид өөрөө аягүй их хэрэгтэй байдаг шүү дээ. Гэтэл маш их ховор болж байна. Энэ бүхэн чинь өөрөө нөгөө олон сошиал дээр их асуудал үүсгээд байгаа. Тэгэхээр бусад улс орон сая та нар Европ бол өөрсдийн зохицуулалтаар явж байгаа гэсэн хэр нь fake news-ийн эсрэг хууль Англи гаргачихсан, Герман гаргачихсан. Бид нарыг энийгээ гаргаач, та нар олон нийтийн сүлжээний хуулиа гарга гээд шахааж шаардаад байгаа шүү дээ. Иргэд

ч шаардаж байгаа. Гэтэл бид гаргах гэхээрээ нөгөө сошиалаасаа айгаад гаргаж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ чинь л бас нэг зөрчил үүсээд байгаа учраас энэ дээр ч гэсэн хамтдаа бодолцох ёстой гэж хэлье.

Н.Энхболд: Баярлалаа. Доржханд гишүүн асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Ямар ч байсан энэ нөгөө танилцуулгатай бол ер нь бол санал нийлж байна. Ер нь их эрүүл ийм уур амьсгал мэдрэгдэж л байна л даа. Тэгээд 1 зүйлийг ингээд нэг тэмдэглэж хэлээд, ганц, хоёр асуулт байна л даа. Одоо дэлхийн 200 улс байгаа. Түүний бараг тал нь шахуу авторитар дэглэмд лүү ингээд гулсаж орж байгаа. Ардчилсан дэглэм нь ингээд цөөрөөд байгаа байхгүй юу. Тэгээд цаашаа энэ байдал ингээд улам гүнзгийрээд байгаа. Тэгээд ардчиллыг ингээд устгадаг 4 зүйлийн нэг нь бол хэвлэл мэдээллийн байдал байдаг. Асар их нөгөө популизм байдаг. Сөрөг хүчний удирдлагуудыг шоронд хийхээс авхуулаад л ингээд л дэлхийн түүхүүд бол байна л даа.

Тэгээд ганц асуудал нь хэвлэл мэдээллийн салбарт санхүүжилтийн л асуудал байдаг. Ерөөсөө л мөнгөтэй хэсэг рүүгээ очоод л нөлөөнд орчихдог. Тэгэхээрээ л ардчилал байхгүй болчихдог. Мөнгө хаана байдаг вэ гэхээр авторитар дэглэмтэй улсуудад бол төр л байдаг. Тэгээд төр барьж байгаа хүмүүс бол мөнгөө төлөөд захиалаад л хөгжмөө захиалчихдаг. Ингээд ардчилал бол байхгүй болдог гээд. Энэ бол дэлхийн маш олон улсуудын жишээ бол байна. Тэгээд Монголд бас нэг ийм нөхцөл байдал байгаа юм байна даа гэж бас мэдрэгдээд байгаа. Тэгээд тэрний эсрэг харин бид нар ингээд илүү дүрэм журам зарчмаа тавьж байгаад, редакцын бодлогуудаа нийлүүлж байгаад энэний эсрэг ингээд явж байгаа юм гэж байгаа бол би бол надад бол энэ их сайхан сонсогдож байна л даа. Улс төрийн намууд ч гэлээ гэсэн нөгөө популистуудыг гаргадаггүй,

популизмаас хол бодлого ярьдаг, энийг өөрсдөө хийх, яг энэ институтийнхээ чанар луу орох ёстой байхгүй юу. Тэгээд хажуугаар нь манай 4 дэх засаглалынхан яг ийм байдлаар ингээд яах юм бол маш сайн. Харин явлаа гээд тэгэхээр зүгээр асуудал нь нөгөө санхүүжилт бол байгаад байдаг.

Тэгээд би бол энэ олон улсын байгууллагуудад ажиллаж байсан хүний хувьд бол олон улсын байгууллагуудын ар талд маш олон улсууд байдаг болохоор эрх ашиг байдаггүй юм шүү. Хүмүүс нөгөө геополитик энэ тэр гээд л янз янзын юм яриад байдаг, тийм юм байдаггүй юм. Байдаггүй юм. Байдаггүй болохоор аль болох нөгөө олон улсын байгууллагуудаас санхүүжилт аваад явах тэр загвар нь бол зүйтэй шүү тийм. Одоохондоо тэрийгээ хаячих, төрийн санхүүжилт бид нар мөнгө нэхээгүй байна, хувийнхан яах вэ. Тэгэхдээ бид нар болж байна. Энэ бол Монголд бас ингээд сайн жишээ болж байна гэдэгтэй чинь би санал нийлээд байна. Цаашаа энэ байдлаараа ингээд яваарай гэж.

2 асуулт байна. Ингээд хүн болгон ингээд хэвлэл мэдээллийн байгууллага болчихсон, сошиалтай болчихсон тийм биз. Тэгээд л сенсац хөөдөг болчихсон. Тэгээд та нар болохоор ингээд сошиалтай бид нарыг битгий хутга, яагаад вэ гээд тэгэхээр бид нар бол редакцын бодлоготой ийм сэтгүүл зүй юм, хэвлэл мэдээлэл юм гээд. Гэтэл нөгөө зах зээл чинь ийшээ хандаад байна шүү дээ тийм биз? Тэгээд зах зээлийн зарчмыг чинь бид нар ингээд зогсооход хэцүү шүү дээ. Тэгээд л нөгөө хандалт хөөсөн ийм сэтгүүл зүй чинь ингээд яваад ирэхээрээ л эргээд л нөгөө ардчилалдаа ингээд хүндрэл үүсгээд байдаг. Тэгэхээр энийгээ та бүгд яг ямар байдлаар хязгаарлах юм бэ? Яг тийм нэг бодлого байдаг юм уу? Түрүүн энд бас нэг Оюунчимэг гишүүн хууль яриад байх шиг байна. Зүгээр олон улсад яг ийм жишиг байдаг юм уу үгүй юм уу гэдэг дээр зүгээр

тэгээд та бүгдийн судалсан юм байвал тодруулж байгаа юм.

Тэгээд 2 дугаарт бас энэ нийт хийж байгаа ажлын дийлэнх нь өргөдөл гомдол байгаад байна гээд. Тэгээд ёс зүй нэхэж байгаа юм байна. Ёс зүйд хариуцлага тавьж байгаа юм байна. Тэгээд түрүүн тэр танилцуулга дотор чинь нөгөө эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухайлбал гол дүрүүд нь маш их гомдогчид байна гээд. Тэгээд ирэхээр тухайлбал хамгийн сүүлийн жишээ маань Өнөрөө гээд Заригийн бүсгүй байна тийм ээ. Тэгээд яг энэ дээр энэ кэйс дээр та бүгд дээр ирсэн гомдол байдаг юм уу? Нөгөө талдаа бас ингээд хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан ийм үйлдэл боллоо гээд танай хэвлэл мэдээллийн ажилтнууд чинь бүгдээрээ ингээд эсэргүүцээд байгаа шүү дээ. Яг энэ дээр та бүгд яг ямар байр суурьтай байдаг юм бэ гэж асуумаар байна? Баярлалаа.

Н.Энхболд: Хэн нь хариулах вэ? 3 номер. Асчихлаа, хариулаарай.

У.Тамир: Байна уу? Яах вэ бид нарын зүгээс бол ер нь эхний ээлжид мэдээж нөгөө редакцтай, редакцын хариуцлагыг сайжруулах тал дээр ажиллаж байгаа яг энэ жишгээрээ. Мэдээж сошиал гарч ирсэнтэй холбоотойгоор редакцууд маань өөрсдөө ч гэсэн сошиал нэйжтэй болж байна. Сэтгүүлчид өөрсдөө сошиалд бас ингээд чөлөөтэй юмаа ярьж байгаа. Энэ нь бас нөгөө буцаагаад ингээд нөгөө сэтгүүлч хүн яг өөрийнхөө редакц дээр болохоор би ёс зүйн зарчмаа барьчихъя. Сошиал дээр бол би өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлж байгаа надад хамаагүй гэсний өнцгөөс ярих гээд байгаа учраас бид нарын хувьд бол албан ёсны редакцын сошиал нэйжтэй холбоотой гомдлыг бол хүлээж авч байгаа. Сүүлийн үед бол тийм өөрчлөлт хийгээд, хүлээж авдаг болсон.

2-т сэтгүүлчид, редакцууддаа ямар уриалга гаргаж, ямар сургалт

хийж явж байгаа гэхээр та нар дотоод нөгөө өөрсдөө редакц болгон энд байгаа ерөнхий ёс зүйн зарчмаасаа үндэслээд илүү редакц болгон өөрийнхөө бодлогод тохируулаад дэлгэрүүлсэн, нарийвчилсан ёс зүйн кодуудаа хийцгээ. Тэрийгээ ил тод зарлацгаа, сэтгүүлчдээ тэрийгээ мөрд. Сошиалд илэрхийлж байхдаа та энэ редакцын сэтгүүлч гэдгээ илэрхийлж байгаа бол сошиалд бас тэр ёс зүйгээ барих ёстой шүү гэдгээ ядаж сэтгүүлч дээр итгэх ёстой гэдэг одоогийн байдлаар бол бид нар ийм өнцөг дээр явж байгаа.

Сая Жаргалмаа гишүүний бас ярьсан нөгөө сургалттай холбоотой асуудал дээр бид нарын хувьд болохоор яаж байгаа гэхээр бас редакцуудтайгаа тулж ажиллаад, сэтгүүлчидтэй тулж ажиллахдаа бид нар дандаа л ёс зүйн зарчим дээр бүх юмаа үндэслэж байгаа юм. Та бүхний яриад байгаа тэр сенсац хөөж байгаа мэдээлэл гэж байна. Энэ чинь манай ёс зүйн зарчим дээр бүгд байж байгаа. Мэдээллийг мушгин гуйвуулахгүй, баримттай, 2, 3 эх сурвалжтай байх ёстой. Энийгээ л барь. Тэгэх юм бол та нарын тэр, тэр битгий дуулиан шуугиан болгохгүй энэ тэр гэсэн заалтууд байгаа байхгүй юу. Энэ заалтаа л барьчих юм бол та нарын энэ юм чинь багасна. Тэгэхээр энэ талд нь нөгөө нэг Оюунчимэг гишүүний хэлснээр сургаж чадахгүй бас сургалт дутуу байгаа тэр сэтгүүлчдийг сургах, редакцуудтайгаа тулж ажиллах ажлыг бид нар давхар хийж байгаа, гомдлын хажуугаар. Нөгөө талдаа сая Оюунчимэг гишүүний хэлсэн тэр эрэн сурвалжлах сэтгүүлчдийг сургах гэдэг бол өнөөдөр үнэхээр манайд дутагдаж байгаа. Мэдээж энийг Хэвлэлийн зөвлөл юм уу аль нэг хэвлэлийн салбар өнөөдөр өөрийн хэм хэмжээнд бол бэлдэж чадахгүй байгаа. Тэгэхээр энийг магадгүй төр дэмжээд бодлоготойгоор эрэн сурвалжлах сэтгүүлчдийг Дойче Велле академийн тусламжтайгаар Хэвлэлийн хүрээлэн дээр багш нарыг бэлдээд, ер нь бол нэг сургалт хийх гэж эхэлсэн.

Харамсалтай нь тэр ажил бас нэг их амжилттай явахгүй байгаа.

Тийм болохоор ингээд сэтгүүлчдээ бэлдэх юманд илүү бас төр анхаарч, мэргэжлийн чанарыг нь дээшлүүлэхэд нь бас та бүхэн анхаарч өгвөл их сайн байна гэж ингээж хэлэх гэж байна. Тэгээд сошиалыг зохицуулж байгаа юман дээр бол яах вэ мэдээж дэлхийн улс орон болгон янз янзаар л хийж байгаа. Европын Холбоо яг хуулиа гаргаад явж байна. Бид нарын зүгээс бол сошиалд бол сая хандсанаа хэлсэн. Бид нар ямар ч байсан эхний ээлжид редакцтай сэтгүүлч рүүгээ хандсан юмнууд руугаа явна. Сошиалын хувьд бол хэрвээ хууль, эрх зүй юу гэдэг юм ингээд зохицуулалт юм хум нь гарна гэх юм бол зүгээр бид нарын энэ нэг ингээд ажиллаж байгаа юмнаас ингээд туршилага ингээд харах юм бол хамгийн гол юм тэр нэр томьёо. Түрүүний нөгөө нэг хууль гараад бас буцсан шүү дээ Сошиалын. Тэрэн дээр ч гэсэн ингээд хараад байгаа юм болохоор юу байж байна гэхээр одоо манайх бол аягүй тодорхой байхгүй юу.

Ёс зүйн зарчим гээд нэг хуультай. Тэр хуулийг зөрчсөн байх юм бол бид нар шууд түүн дээр дүгнэлтээ гаргаад л чи ёс зүйн зарчмыг ингээд зөрчсөн гээд хэлчихдэг. Тэгтэл сошиалд байгаа юмыг ерөөсөө ихэнхдээ харахаар нөгөө гүтгэх доромжлох, нэр төрд халдах гэсэн үндэслэлээр л яваад байх шиг байгаа юм. Тэгээд тэр нь Эрүүгийн хуульд болохоор нөгөө нэг ийм нарийвчилсан fake news-ийг чинь ингээд ямар бол хуурамч, ямар бол яах вэ гээд бас нэг ЮНЕСКО энэ тэрнээс чинь тодорхойлолт гаргаад, ингээд ялгах гээд байгаа байхгүй юу. Тэгээд тэр нэр томьёоны тодорхойлолтоо сайн ялгаж өгөөгүйгээс болоод мэдээж цагдаа, шүүгч ч гэсэн тэр асуудлыг чинь шийдэж чадахгүй байгаад байна гэдэг нь энэ дээрээ ирээд байх шиг байгаа юм. Тэгэхээр нэр томьёо бүх юмнуудаа нэг ойлголттой болгоод, тэгээд хуулиа хийхдээ бол яг тэрэндээ тохирсон юу нь

гэмт хэргийн шинжтэй байх юм эсвэл юу нь өөрийн зохицуулалт руугаа явах юм эсвэл юу нь яах юм гэдэг юмнуудаа ялгаж харж хийх ёстой юм болов уу? Нөгөө талдаа хууль гаргахаар одоо байгаа хууль хүчний байгууллагуудад.../минут дуусав/

Н.Энхболд: Тодруулъя. Доржханд гишүүн.

Т.Доржханд: Тэгэхээр уг нь нөгөө олон улсад нөгөө fake news гээд нэг ийм trash box байдаг. Тийшээ ингээд хаяад байдаг. Өөрөөр хэлэх юм бол ийшийгээ орсон мэдээлүүд дандаа хуурамч шүү гээд тийм биз? Тэгээд энийг бол нөгөө танайхаас л хийвэл их зохимжтой юм шиг санагдаад байна л даа. Бид нар зүгээр бодож байсан юм. Одоо сонгууль дөхөөд ирэхээр хүний нэр хүндэд халдсан, худлаа харлуулсан мэдээ их явдаг шүү дээ. Тэгээд тэрийг нь ингээд шидээд байдаг, тэр эх үүсвэрийг нь харахаар аан ингээд энд нэг. 2-т нь болохоор нөгөө сургалт аягүй чухал л даа. Тэгээд бид нарын зүгээс ингээд маш олон мэргэжилтнүүд байдаг. Заавал улс төр биш л дээ. Сургамаар байна шүү дээ. Би эдийн засгийн олон улсын эдийн засаг ярьж өгмөөр байна. Дэлхийн эдийн засаг ярьж өгмөөр байна. Тэгээд маш олон чиглэлийн мэргэжилтнүүд ингээд та бүгдэд ингээд ярьж өгөхөд бид нар бэлэн шүү. Тэгээд заавал төр гэхгүйгээр өөрсдийнхөө боломжоор ингээд бие биеэ ингээд мэдлэгжүүлээд мэдээлэлжүүлээд явах юм бол цаашаа иргэддээ мэдээлэл өгмөөр байна шүү дээ.

Өнөөдөр сонгуулийн тогтолцоо мэдэж байгаа сумдад нэг ч хүн байхгүй байна шүү дээ. Яагаад гэвэл тийшээ хүрч мэдээлэл өгч байгаа нэг ч хүн алга. Яагаад гэвэл тэр сонирхолтой биш байна шүү дээ.

Н.Энхболд: Баярлалаа. Товчхон Гүнжидмаа нэг хариулт өгчих.

Г.Гүнжидмаа: Сошиал медиаг яаж зохицуулах вэ гэдэг дээр бас санаа хэлэх гэсэн юм. Энэ сэдвийг бол манай байгууллага бас хөндөөд л явж байгаа. Гэхдээ энэ Герман болоод Европын орнууд ихэвчлэн платформыг үүрэгжүүлж байгаа. Бүх нөгөө хүний эрхийг хангах, хүүхдийн эрхийг хангах бүх зүйл бол нөгөө офлайн, онлайн орчинд бол зэрэг хамгаалагдана, хүчин төгөлдөр. Тэгэхээр бид нар яг энэ тусгайлж гарч байгаа юм болбол энэ нөгөө мета байна уу, фэйсбүүк байна уу энэ компаниудыг илүү өргөжүүлэх тал руу хийж байгаа. Тийм учраас бид нар компаниуд руу илүү хандсан зохицуулалтуудаа харж, харин өөрсдийнхөө нөгөө иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бас аль болох хамгаалж үлдэх нь ардчилалд аягүй хэрэгтэй гэж бас харж байгаа.

Н.Энхболд: Тасарчихлаа. 2 номерыг өгөөдөх, 1 минут.

Г.Гүнжидмаа: НҮБ энэ дээр анхаарал хандуулчихсан байгааг би түрүүн дурдсан. Тэгэхээр тэд нар хуулийн зохицуулалтуудыг тодорхой хэмжээнд хийгээд, тэр хулгай дээрэмтэй холбоотой дээр нь хийгээд бусад зүйл дээр нь яг өөрийн зохицуулалтыг хийхээр явж байна. Тэр нь болохоор сошиал медиад ёс зүйн дүрэмтэй байя гэдгийг НҮБ гаргаж ирээд, өчигдөрхөн НҮБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар хэлэлцүүлж эхэлж байна. Тэнд бол яг л энэ нөгөө жишигээрээ яг медиа салбартаа хэвлэлтэй адилхнаар явж байгаа гэдгийг хэлье.

Түрүүний нөгөө хэнтэй Өнөрцэгтэй холбоотой кэйс дээр манай дээр яг ижил гомдол ороод ирчихсэн. Нэг, Хэвлэлийн зөвлөл бол өөрөө дундын байгууллага. Энийг хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалдаг байгууллага болбол манайх биш юм. Манайх нөгөө олон нийт 50 хувь дээр нь, 50 хувь дээр нь хэвлэл мэдээлэл гэж явж байгаа. Тэгэхээр яг энэ адилхан кэйс шүүх дээр ШЕЗ-өөс гарсан

Кэйс шүүх рүү яваад л манай дээр адилхан ирчихсэн. Бид нар энэ 7 хоногт энийг хэлэлцэн шийдэх ийм үүргийг манай Ёс зүйн хорооны гишүүд хүлээчихсэн сууж байгаа. Бид нар Зариг сайтыг болбол сайтынх нь хувьд ч хаасныг болбол энэ бол хэвлэлийн эрх чөлөөний том зөрчил гэж мэдэгдэл гаргасан. Ийм зүйл дээр бид нар аль болох дуу хоолойгоо.../минут дуусав/

Н.Энхболд: Баярлалаа. Бас нэлээн хэрэгтэй сонсгол, ярилцлага болж байна гэж бодож байна. Би нэг хэдэн зүйл асуучихъя. Та нар товчхон хариулахыг бодоорой. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэл мэдээллийн зөвлөл 2 хоорондоо ер нь хэр зэрэг уялдаа холбоотой, бие биеийгээ хүлээн зөвшөөрч, гар нийлж ажиллаж байгаа вэ нэгд? Маш тодорхой асуулаа шүү.

2 дугаарт энэ сая олон хүмүүсийн яриан дундаас ингээд бас нэг ийм асуулт өөрөө ургаад гараад ирж байна л даа. Та нар бол сэтгүүлчдийн хүрээнд сэтгүүлчидтэйгээ холбогдсон үйл ажиллагаа явуулдаг байгууллага тийм ээ. Хэнийг өнөөдөр Монголд сэтгүүлч гэж үзэж байгаа вэ? Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлд бүртгэгдсэн албан ёсны гишүүн хүмүүсийг үзэж байна уу? Танай холбоонд танай эвлэлд, зөвлөлд бүртгэгдсэн хүмүүсийг үзэж байна уу эсхүл нэг би өөрөө би сэтгүүлч учраас бусдаас давуу эрхтэй гэж яриад яваад байгаа тэр хүмүүсийг үзэж байна уу? Асуудлыг нь та нар аль хүрээнд авч үздэг юм, хэнийг яг сэтгүүлч гэж үзээд байна вэ өнөөдөр Монголд? Эндээс чинь нөгөө сошиалын сэтгүүлчдийн байгууллагуудын, редакцуудын хоорондын зөрөө энэ маш том явж байна шүү дээ. Та нар одоо жишээ нь зарим хүнийг наадах чинь бол сэтгүүлч биш, хувь хүнийхээ л юмыг илэрхийлж байгаа шүү, ийм хүн шүү гээд ийм хүн шүү, ийм сайд шүү гээд хэлчихвэл, тэгээд тэр нийгэмд бас тодорхой хэмжээний юу болно. Баримжаа тийм ээ. Энэ бол яг өөрийгөө бусдын төлөө сайн сайхны

төлөө явж байгаа мэргэжлийнхээ үүднээс ажилд хандаж байгаа сэтгүүлч хүн байна гэж хүлээж авна. Эсхүл энэ бол сэтгүүлчдэдээ сэтгүүлчдийнхээ байгууллагад сэтгүүлч гэж хүлээн зөвшөөрөгдөөгүй хүн байна гээд ойлгогчихно гэдэг бол тэр дундаас их том ялгаа гарах ёстой шүү дээ. Тэгэхээр өнөөдөр хэнийг та нар сэтгүүлч гэж үзэж байна вэ? Энэ нэг ийм 2 дахь асуудал байна.

3 дугаарт яах вэ энэ дараагийн асуудал. 3-д нэг ийм зүйл байна. Ер нь Монгол Улс өөрөө төрийн байгуулалтын хувьд нэгдмэл ийм улс. Бидний хувьд энэ эмзэг орчин тойронтой улсын хувьд эв нэгдэл, үндэсний эв нэгдэл, нийгмээрээ бас нэг нийтлэг үнэт зүйлтэй байх тухай асуудал болбол онцгой чухал ийм улс шүү дээ. Тэгээд зүгээр сэтгүүлчдийн дундаас гарч байгаа материалаас ч, сошиал дээрээ байгаа материалаас үзэхэд энийг ерөөсөө харахгүйгээр л зүгээр л шуугиан сонирхол, хэн нэгэнд үйлчилсэн ийм л юм байвал хамгийн их хандлага авдаг энэ орчин мэдээллийн орчинтой үед та бүхэн өөрснөө жишээ нь энэ үндэсний нийтлэг эрх ашгийг өмнөө тавьж ажиллана гэдэг бол ёс зүйтэй ажиллах мөн үү эсхүл тэр хамаагүй байдаг уу? Ийм том сууриар нь авч үздэг үү, тийм шаардлага тавьдаг уу сэтгүүлчидтэй, бүртгэлтэй улсууддаа? Өөрснөө сэтгүүлч гэж үзэж байгаа энэ хүмүүст. Энэ нэг ийм 3 дахь асуудал асуулт байна.

Яах вэ, бид нар ингээд дараа нь болбол би зүгээр байр сууриа хэлье. Хэрэгтэй яриа болж байна гэж үзэж байна. Та нарын яриан дундаас жишээ нь надад болбол ямар зүйл маш тодорхой 2 зүйл юу гэж бодогдсон гэхээр тэр өөрийн зохицуулалтын асуудлыг нэг бас хуульчлаад тийм ээ, хуульд тусахдаа бүүр хуульчилж өгдөггүй юм гэхэд эхлээд өөрийн зохицуулалт нь явж байж, дараа нь эрүү бусад юм руу орно шүү гэдэг юмыг нэг бодлогын хэмжээнд их ойлголцох хэрэгтэй юм байна. Тэрийг нь хуульд биш юм гэхэд бодлогын баримт

бичгүүдэд ингээж эсхүл харилцан ойлголцсон санал, санамж бичиг ч байдаг юм уу тийм ээ ийм юманд тусгах их чухал юм байна гэдгийг бид нар үргэлжлүүлээд ярьж болох нэг сэдэв байна гэж ойлгож байна. Тэгээд та нар үнэхээр чадах уу тэгж?

Жишээ нь тийм хэмжээнд ингээд бодлогын баримт бичиг гаргачихлаа гэж бодоход бид болбол энүүгээр сэтгүүлчдээ ойлголцоод, зохицуулаад байна гэж бүрэн дүүрэн итгэлтэй хэлж чадах уу, дүрэмгүйнүүдийг нь ялгаж чадах уу? Түрүүчийн миний сэтгүүлчийн гэдэгтэй л, хэн бэ гэдэгтэй ойрхон асуудал л даа. Тийм. Зарим хүмүүсийг та нар наадах чинь сэтгүүлч биш гэж зарлаж байсан ийм тохиолдол байна уу, чадаж байсан уу ер нь? Тэгэхээр тэр нөгөө дараалал шийтгэлийн юм уу, хариуцлага хүлээх дарааллын тухай асуудал дээр энийг бид нар үргэлжлүүлээд ярьж болно гэж бодож байна. Тийм. Эхлээд, тэгэхдээ энэ та бүхэн, танайх, тэгээд Сэтгүүлчийн нэгдсэн эвлэл энэ дээр үнэхээр чанга байр суурьтай, нийгэмд хүлээн зөвшөөрөх хэмжээнд ажиллаж чадвал энийг бодлогод оруулаад, энийг заавал тийш нь заавал хууль руу чирээд байхгүй, өөрийн зохицуулалтад томоохон найдлага тавья гэдэг чиглэлээр хэдүүлээ хамтраад ажиллаж би болно гэж бодож байна. Энэ бол та нарын ажлын үр дүн, нэр хүндээс ихээхэн шалтгаалах ийм ажил шүү гэж бодож байна. Өнөөдрийн ярианаас гарах нэг үр дүн бол тийм ээ.

2 дугаарт зүгээр яг нэг бодитой ажил хийвэл жишээ нь манай Байнгын хорооноос зохион байгуулаад сэтгүүлчдийг зөвхөн та нар өөрснөө хоорондоо ярих бололцоог чинь бүрдүүлж өгөөд, танай зөвлөл, Сэтгүүлчийн нэгдсэн эвлэл хамтраад сэтгүүлчдийнхээ хүрээнд та нар өөрснөө сэтгүүлч гэж үздэг тэр хүрээндээ илэн далангүй нэг ийм яриа, бага хурал, бага хурал гэхэд хаашаа юм, санал солилцох, нэгдсэн ойлголтод хүрэх тийм арга хэмжээ зохион байгуулна гэвэл энийг

жишээ нь ТББХ-ны зүгээс албан ёсоор зохион байгуулж өгөөд, сэтгүүлчдийг сэтгүүлчидтэй нь уулзуулах гээд байна шүү дээ тийм ээ. Энэ юмыг бид нар хийж өгч болж байна. Тодорхой хэмжээний зардал мөнгө гаргаж өгч болно. Тэгэхдээ бид орохгүйгээр, зөвхөн та нар хоорондоо суугаад нэг яг энэ ёс зүйн асуудлаа нэг яриач. Тэгээд энэнээс чинь үргэлжлүүлээд хэдүүлээ тэр эхлээд өөрийн зохицуулалтаар нь юмнуудаа шийддэг юм руугаа оръё бүгдээрээ хүлээн зөвшөөрөөч. Дараа нь тэр Эрүүгийн бусад шийтгэлийн хуулиудад ямар зохицуулалт нь байх вэ тэр юмнуудаа ингээд, бүгд та нар энэ нөгөө зөвхөн хоорондоо яриад гараад ирээд нэг ийм түвшинд үйл ажиллагаа явуулж болж байна гэсэн санал нэгдсэн юмаар гараад ирвэл тэрийг ёстой Байнгын хорооны зүгээс санал болгоод юм уу, хууль санаачлаад эсхүл эрх зүйн баримт бичиг боловсруулаад, хууль биш юм гэхэд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ийм бодлого барих гэж байгаа юм байна. Энэ чиглэлээр нь ажиллая гээд гишүүдэд Улсын Их Хуралдаа ойлгуулаад, уриалаад явах ийм 2 боломж байна гэж харж байна. Тэгээд би түрүүчийнхээ 2, 3 асуултад хариултууд авъя. 2 номерын микрофон.

Г.Гүнжидмаа: Баярлалаа. Тэгээд саналууд бас хүлээж авахдаа таатай байх болно. Энэ бол бүх хэрэгжих боломжтой зүйлүүд. Яагаад гэвэл бид нар 10 жил хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хийгээд ирсэн энэ туршилага нөөц, энэ зөвхөн 4, 5-хан хүний асуудал биш, энэ салбараараа сэлгэгдсэнээр тооцвол 60 орчим энэ салбарын хүмүүс энэ өөрийн зохицуулалтад орж ажиллаж, үнэ төлбөргүйгээр орж ажилласан туршилага байна. Тодорхой хэмжээнд энэ институт нь бол хөгжсөн учраас бид нар энийг бүүр бүрэн боломжтой гэж харж байгаа. Тэр хамтарсан уулзалт хэлэлцүүлэгт бид нар бас нээлттэй байх болно, дэмжиж байна гэдгээ илэрхийлье.

Асуултуудын хувьд ХМЗ-ийн өөрийнх нь үнэт зүйл яг энэ хамтын хэлэлцээрийн, хамтын хэлэлцээр, эв нэгдлийг эрхэмлэсэн, зөвшилцөлд суурилсан, үнэт зүйл, ёс зүйн үнэт зүйлийг нийгэмд бий болгохын төлөө явж байгаа. Тэгэхээр яг энэ суурь утгаараа үндэсний аюулгүй байдал, улс орны эрх ашгийн төлөө ардчиллын тулгуур баганын хувьд гэж бид нар харж, өдөр тутмын үйл ажиллагаагаа бодлогынхоо баримт бичгүүдийг ч гэсэн ийшийгээ чиглүүлж явдаг гэдгийг бас хэлье. Тэгээд энэ тал л дээр бас ХМЗ өргөн утгаар нь ажиллахыг бас зорьж явдаг.

Сэтгүүлч гэж хэн юм бэ гээд. Энэ бас их тодорхойлоход маш ярвигтай зүйл юм. Яагаад гэхээр энэ өөрөө нөгөө үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй шууд холбогддог. Энэний илэрхийлэмж болж гарч ирж байгаа учраас. Тэгээд дэлхийн улс орнууд ялангуяа ЮНЕСКО-оос сэтгүүлч гэдэг хүн болбол зөвхөн дипломтой хүнийг хэлж болохгүй юм. 2-т нь сэтгүүлч гэж ямар ч лиценз олгож болохгүй юм. Энэ бол үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний шууд хориг саад болно. Ийм учраас тодорхой хэмжээнд хэвлэн нийтлэх ажлыг хийж байгаа, редакцад ажиллаж байгаа, тодорхой хэмжээнд өөрийнхөө ажил хөдөлмөрийн хөлсний тодорхой хэмжээг эндээс босгож явж байгаа болбол чөлөөт уран бүтээлч байна уу, редакцад ажиллаж байна уу, бид нар энийг бол сэтгүүлч гэж ойлгоно гэж гаргасан.

ХМЗ-ийн зүгээс бид нарын хэлдэг зүйл танд барьдаг мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй буюу та энэ кодыг мөрддөг үү? Та код мөрдөж ажилладаг бол таныг бид нар сэтгүүлч гэж бас ойлгож болно гэдэг энэ чиг хандлагаар болбол бас явж байгаа. Монгол, хэвлэл мэдээллийн салбар аль ч улс орны хувьд 3 тулгуур баганатай. Тэр тулгуур 3 багана нь бат бөх хөгжсөн цагт аягүй нөгөө дүр төрхөө олно гэж хэлдэг. Энэ нь бол 1 дүгээрт Эздийн холбоод. Эздийн эрх ашиг тусдаа байдаг. Энэ бол бизнесийн

эрх ашгийн асуудал яригддаг. 2-т нь сэтгүүлчдийн эрх ашгийн асуудлыг хариуцдаг Сэтгүүлчдийн холбоо. 3-д нь өөрийн зохицуулалт буюу ёс зүйн асуудлаа хариуцдаг. Тэгэхээр энэ тулгуур 3 баганыг жигд хөгжүүлэх асуудал манай бас бодлогын асуудал байгаа юм. Улс орны ч гэсэн бодлогын асуудал тийм ээ. Тэгэхээр энэ дээр өнөөдрийн байдлаар сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалдаг, сэтгүүлчдийг яг нөгөө мэргэжлийн эрх ашиг руу нь явдаг, сэтгүүлчдийн үйлдвэрчний эвлэл тал руу нь илүү хөтөлж явдаг байгууллага бол бид нар Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийг гэж хардаг. Эздийн холбоод болбол өдөр тутмын сонинны холбоо, телевизүүдийн холбоо гэх мэтчилэн хэд хэдэн холбоодууд эздийн холбоодууд бол байдаг.

Холбоодын хөгжил Монголд бас л явж байна. Энэ бас ингээд жил ирэх тусам дүр төрхөө олох байх гэж найддаг. Энэ 2 холбооны төлөөлөл, энэ 2 холбоодын хэлэлцээрээр өөрийн зохицуулалтын байгууллага бий болдог. Энэ жишгийн дагуу 2015 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл ёс зүйн хүрээний мөрдөж сэтгүүлчдээ мөрдөөч гэж уриалж байсан энэ ёс зүйн дүрмээ Хэвлэл мэдээллийн зөвлөлд шилжүүлээд, Хэвлэл мэдээллийн зөвлөлийг бол бид нар дотор нь орохгүйгээр гаднаас нь дэмжиж ажиллана гэдэг энэ бодлогыг тухайн үед бол гаргаж байсан. Яг энэ зарчмынхаа дагуу бид нар өнөөдөр өөр өөрсдийнхөө үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлээд л, тодорхой хэмжээнд эрх зүйн шинэчлэлтэй холбоотой асуудлууд дээр ч юм уу дуу хоолойгоо нэгтгээд ингээд явдаг байгаа.

Н.Энхболд: Баярлалаа. Тийм нэг нь үйлдвэрчин маягаар илүү эрх ашгийг нь хамгаалдаг, нөгөө нь ёс зүй талаасаа л, хоорондоо холбоотой л асуудал шүү дээ тийм ээ. Ёс зүйгүйгээр эрхээ эдэлнэ гэж байхгүй, эрхээ хамгаалуулна, ёс зүйгүйгээр эрх эдэлнэ, ёс зүйгүйгээр эрхээ хамгаална гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр

та нарын ажил бол их уялдаатай л байх ёстой. Тэгээд тэр үүднээс миний манай Байнгын хороонд оролцсон хүмүүсийн зүгээс санал болгож байгаа зүйл бол та нар бөөнөөрөө цуглаад, энийг нэг бүүр зориуд нэг удаа бас нэг арга хэмжээ болгоод зохион байгуулъя гэвэл бид бэлэн байна шүү. Энийг чинь харгалзаж байгаад тэгээд дараа дараагийн тийм бодлогын суурь болох жишээ нь эхлээд өөрийн зохицуулалтын байгууллагуудаар нь юмыг нь явуулдаг энэ уур амьсгалыг бий болгох, болж өгвөл энийг нь ямар нэгэн бодлогоор юм уу, эрх зүйн баримтаар дэмждэг энэ асуудал үргэлжлээд, үргэлжлүүлээд суурилоод тэрэн дээр түрүүчийн юман дээр нь суурилоод явж болох юм гэсэн ийм зүйлийг өнөөдрийн зүгээр, уг нь бид нар зүгээр сонсоод л өнгөрөх ёстой юм. Тэгэхдээ бид нар бас тодорхой санал дэвшүүлээ шүү тийм ээ. Та бүхэн бодож үзээд, тэгээд эргээд хариу хэлээрэй. Баярлалаа. Өнөөдрийн ТББХ-гоор Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажлын талаар мэдээлэл авах, сонсгол авах ажиллагаа дууслаа. Оролцож ирсэн та бүхэнд баярлалаа.

14.00 цаг

Хэлэлцэх асуудлууд дууслаа.
ТББХ-ны өнөөдрийн хуралдаан дууслаа.
Оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА